

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи ба хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл




Зургийг Евгений Полонский

Казахстаны бөхөнгийн нүүдэлд заналхийлж буй хаалтууд

Стефен Зутер, КБТЗХН, steffen.zuther@acbk.kz

Устюртын бөхөнгийн популяцийн нүүдэл, шилжилтэнд чухал нөлөөтэй Устюртын талд Казахстан, Узбекистаны хил дагуу торон хашаа баригдаж байгааталаар Бөхөнгийн мэдээний өмнөх дугаарт (БМ #15, 16) мэдээлж байсан. 2011 болон 2012 онд тодорхой тооны амьтанд зүүсэн сансрын дохиололтой хүзүүвчний мэдээлэл нь өргөст торыг хөндлөн гарах хүртлээ эсвэл цоорхойг олох хүртлээ торон хашааны дагуу шилжилт хөдөлгөөн хийдэг болохыг тодорхой харуулсан.

Төгсгөл 2-р хуудсанд.



Өргөст тороор хийсэн байгальд ээлтэй хашааны жишээ
В хувилбарт Устюртын талд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хашаа

Энэ хэвлэлийг ивээн тэтгэсэн:

Агуулга

Гол мэдээ

Стефан Зутер. Казахстаны бөхөнгийн нүүдэлд заналхийлж буй хаалтууд..... **1**

Шинэ мэдээ

Стефан Зутер&Алена Шмаленко. Казахстанд болсон малын эмч нарын хурал..... **3**

Стефан Зутер&Олег Лукановский. Бетпақдалагийн популяцийн тархац нутагт буй ТХГН-г үзүүлсэн дэмжлэг..... **4**

Виктор Григорьев. Хүүхдийн тоглоомын тухай түүх дэлхийг өөрчилж байна..... **5**

Айгүл Айтбаева &Наталья Шивалдова . Бөхөнгийн өдөр - 2014..... **6**

Б. Чимэддорж . Монголын бөхөнгийн анчдыг шийтгэв..... **9**

Лийжах Дорвард &Петер Дамерелл. Бөхөн нөөцийн төвийн мэдээ..... **10**

Хэвлэлийн мэдээ..... **10**

Степной БНГ бөхөнд зориулан “Төллөх үеийн асрамжлан хамгаалах” газрыг бий болгов.

Казахстаны бөхөнгийн популяци 3 дахин өсчээ

Казахстанд хууль бус бөхөнгийн агнуур зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдлоо.

Хууль бусаар хил давуулж буй бөхөнгийн эврийг илрүүлэхэд үнэрч нохой ашиглаж байна.

Узбекстанд бөхөнгийн зурагтай шуудангийн марк хэвлэгдэн гарлаа.

Өгүүлэл

Рори Мас Канн&Олга Еситова. Хамтдаа зурав-Узбекстаны зэрлэг ан амьтад болоод хүмүүс..... **12**

Киан Хуанг ба бусад. Хятад дахь бөхөнгийн түүхий эд эрхтний уламжлалт эмчилгээний зах зээл..... **14**

Николай А.Франов. Астрахан мужид бөхөнгийн ороо хөөцөөний үед эр бөхөнг байгальд нь буцаан тавьлаа..... **16**

Вадим Н. Ягодина,Ш.Ш.Амиров. Устюртын тал дахь эртний агнуурын байгууламж..... **18**

Бөхөнгийн баатар

Юрий Грачев, Казахстан **20**

Мэдээлэл

Байгаль хамгааллын залуу удирдагч шагнал 2014 **21**

БХН тус нийгэмлэгийн ивээн тэтгэгч, найз Жой Ковейгийн дурсгалд зориулан бөхөн хамгаалах шагналыг олголоо..... **23**

Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэг Дэвид Маллоний бөхөн хамгаалах талаар хийсэн ажлыг үнэлж байна..... **23**

Төгсгөл (Эхлэл 1-р хуудсанд.)


Бөхөнгийн шилжилт хөдөлгөөнд тулгарч байгаа өөр нэг асуудал бол Бетпақ-дала болон Устюртын бөхөнгийн популяцийн тархац нутгийг дайран өнгөрч буй Зеказген, Бюнеу хотыг холбосон шинэ төмөр замыг барьж буй явдал юм. Казахстаны төмөр зам компаниас хэрэгжүүлж төсөл болох уг төмөр замыг 2016 онд бүрэн ашиглалтанд өгөхөөр төлөвлөж байгаа хэдий ч 2013 онд бүтээн байгуулалтын ихэнх ажлыг нь гүйцэтгэсэн. Далангийн шороон овоолго болоод үндсэн зам аль хэдийн дуусжээ.

Олон улсын шинжээч Кирк Олсон КБТЗХН-ийн урилгаар Казахстан улсад айлчлан холбогдох талуудтай уулзсан бөгөөд бөхөнд эдгээр шугаман дэд бүтцээс үзүүлж буй нөлөөллийг тогтоох, сөрөг нөлөөллийг бууруулах боломжит арга хэмжээг тодорхойлох, хилийн тор болон төмөр замын тухай нарийвчилсан мэдээллийг авсан. Энэ ажлыг ЗАНЗХК-иас санаачилсан бөгөөд Франфуртын Амьтан судлалын нийгэмлэг, Шувуу хамгаалах Эзэн хааны нийгэмлэгээс санхүүждэг Алтын-дала хамгааллын санаачилга, Олон улсын амьтан ургамал хамгаалах холбооноос хэрэгжүүлдэг USAID-аас санхүүжилттэй Устюртын ландшафтыг хамгаалах санаачилга зэрэг Казахстанд ажиллаж буй хоёр төсөл хамтран дэмжлэг үзүүлсэн.

Хоёр долоо хоногийн томилолтын хугацаанд засгийн газрын холбогдох яамд, инженерийн компани, эдийн засгийн хүрээлэн болон Казахстаны хил хамгаалах албаныхантай хэлэлцүүлэг хийсэн. Оролцогч бүх талууд бөхөн хамгаалах асуудалд дэмжлэг үзүүлэх болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэлэлцэхэд нээлттэй оролцсон. Үүний үр дүнд зэрлэг амьтдын нүүдэл шилжилт хөдөлгөөнд шугаман дэд бүтэц бүхий объектууд, ялангуяа хилийн тор болон төмөр замын сөрөг нөлөөллийг бууруулах хэд хэдэн сонголтыг тусгасан нарийвчилсан зөвлөмж бүхий дэлгэрэнгүй тайланг боловсруулан гаргажээ. Уг тайланд хилийн торон хашааны сөрөг нөлөөллийг бууруулахад бөхөн болоод бусад амьтдын торон хашааг үхэл хорогдолгүйгээр даван гарах нөхцлийг хангахын тулд газар болоод доод талын төмөр утасны хоорондох зайг ихэсгэх зорилгоор торон хашааны доод талын төмөр утсыг бүр мөсөн авах нь хамгийн тохиромжтой шийдвэр болох талаар дурджээ. Төмөр замын асуудал илүү нарийн, төвөгтэй юм. Зэрлэг амьтдын хувьд бодит хаалт болох энэхүү үйл ажиллагаа нь тулгарч буй асуудлын нэг тал юм. Иймээс бөхөнд зориулсан тусгай гарц орчмын далангийн овоолго шорооны налуу нь хүрээлэн буй орчинтойгоо зохицсон илүү тэгшивтэр байх ёстой гэж КБТЗХН зөвлөж байв. Энэ нь хаалтын нөлөөг бууруулах, амьтад зам хөндлөн гарахад хялбар болох зэрэг үр дүнтэй.

Ийм 86 гарцыг зам барих төлөвлөгөөний баримт бичигт багтаан оруулсан. Гэвч үүний цаана төмөр замтай холбогдон гарах ирээдүйн дэд бүтцүүд, ялангуяа хүн амын суурьшил бүхий өртөө, түүнчлэн төмөр замтай паралел машин зам нь бөхөнгийн тархалтын зүй тогтолд нөлөөлж болох юм. Мал сүрэг болон нохойн тоо толгой үүссэнээр өрсөлдөөнийг үүсгэж болохоос гадна суурин газрууд нь хулгайн анчдын орогнох газар болж болох юм. Иймээс тусгагдсан зөвлөмжүүдийн нэг нь тогтвортой байршил бүхий бөхөнгийн тархац, амьдрах орчинд байх хүн амын суурьшил байхгүй газарт байгуулахаар төлөвлөгдсөн өртөөг буцаан татах явдал байсан.

Энэхүү зөвлөмжийг тоймлон гаргаж холбогдох засгийн газрын хүмүүст хүлээлгэн өгсөн. Хилийн торон хашаатай хамаатайгаар Арал тэнгисийн эргээс эхлэн



Бетпак-далагийн бөхөнгийн популяцийн тархац нутгийг дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн хэсгийн тойм Одоогоор “Промежutochnaya” өртөөнд хүн амын суурьшил байхгүй байна.

ойролцоогоор 138 км зайд нэг км тутамд торон хашааны доод утсыг бүрмөсөн авч бөхөнгийн гарц хийхийг хил хамгаалах алба хүлээн зөвшөөрсөн бөгөөд 138 гарц байгуулсан.

ШИНЭ МЭДЭЭ

Казахстанд болсон малын эмч нарын хурал

Стефан Зутер & Алена Шталенко, КБТЗХН, steffen.zuther@acb.kz

Сүүлийн жилүүдэд бөхөн бөөнөөрөө үхэж хорогдож байгаагийн улмаас мал эмнэлгийн байгууллагуудыг оролцуулсан хоёр хурлыг НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн холбоо (FAO), КБТЗХНХАА-н яамны Мал эмнэлгийн хяналт, үйлчилгээний зөвлөлтөй хамтран 2013 оны 11 сард Астанад зохион байгуулсан. Эхний гурван өдрийн хурал нь зэрлэг ан амьтдын үхлийн шалтгааныг тодорхойлоход байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулахад чиглэгдсэн. Урал болон Бетпакдалагийн популяцид нүүрлэсэн бөөнөөрөө хиарах тохиолдлоос авсан сургамж нь тухайн бүс нутагт нөхцөл байдлыг бодитойгоор сайжруулах шаардлагатайг харуулсан. Иймээс мал эмнэлгийн хүрээлэн, лаборатори, орон нутгийн засаг захиргааны төлөөлөлүүд зэрлэг ан амьтдын үхэл хорогдолд үзүүлж буй нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг сайжруулах, зэрлэг ан амьтдын эрүүл ахуйн асуудлаар сургалт авах зорилгоор Астанад чуулав.

Бөхөнгийн бөөнөөрөө үхэх өвчлөлийн Стандартлагдсан үйл ажиллагааны журмыг хэлэлцэн хурлаар баталсан. Үхсэн амьтдын задлан шинжлэхэд хэрэглэгдэх багажийн жагсаалт, протоколыг батлан, оролцогчдод тараасан. Эцэст нь энэхүү бөөнөөрөө хиарах үзэгдлийн учир шалтгааныг тогтоох бүлгийг (Rapid Response Group) байгуулах саналыг гаргасан.

Хоёрдахь хурлаар “Нэг эрүүл ахуй” ерөнхий үзэл баримтлал болон бөгөөд зэрлэг амьтан-мал-хүний хоорондох өвчний хяналтын асуудлыг тодорхойлоход илүүтэй анхаарал хандуулсан. Уг хуралд оролцогчид бөхөнгийн тархац нутагт ажиллаж буй эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, мал эмч нар, засаг захиргааны харъяа нэгжүүд оролцсон.



Зургааны КБТЗХН

Эхний хурал дээр Лондонгийн Эзэн хааны мал эмнэлгийн коллежийн проф. Ричард Кок илтгэл тавьж байна.

Үргэлжилсэн сонирхолтой лекц, асуудалд суурилсан дадлага ажлын дараа Стандарт үйл ажиллагааны журам, Учир шалтгааныг тогтоох яаралтай нэгжийн зарчмыг баталсан. Энэхүү хурал нь 2013 оны 9 сард бөхөнгүүд бөөнөөрөө үхсэн нутаг руу аялал хийснээр өндөрлөв. Уг хурлаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг энэ жилийн сүүлээр албан ёсоор батлуулах, төрийн холбогдох газруудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хэлэлцүүлэг явуулах болно.



Зургийг КБТЗХН

Хоёрдахь хурлын үеэр тавьсан илтгэл.

Бетпак-далагийн популяцийн тархац нутагт буй ТХГН-т үзүүлсэн дэмжлэг

Стефан Зутер&Олег Лукановский, КБТЗХН, steffen.zuther@acbk.kz

Төв Казахстаны Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн тархац нутгийн баруун хэсэгт оршиж, бөхөн хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Иргыз-Тургай БНГ, Алтын Дала БНГ зэрэг хоёр тусгай хамгаалалттай газар нь 2007 болон 2012 онд шинэ багаж төхөөрөмж болон техникийн дэмжлэг туслалцаа хүлээн авсан. Тэдгээрийн үндсэн зорилгын нэг нь жил бүр бөхөнгийн ороо хөөцөө, төллөлт тогтмол явагддаг, удаан хугацаанд ашиглагдсаар ирсэн тухайн бүс нутагт бөхөнг хамгаалах явдал юм.

Харамсалтай нь дээрх хоёр нутагт эвэр авах зорилгоор хийгдэж буй хулгайн анчдын бодит аюул нүүрлэсээр байна. Хамгаалалтын захиргааны ажлыг дэмжих, тэдний үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох зорилгоор КБТЗХН нь тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэн, Алтын дала хамгаалах санаачлагын нэг хэсэг болгон хамгаалалтын захиргааны ажилтнуудад сургалт зохион байгуулж байна. Иргыз Тургай БНГ-т 2013 оны зун 3 техник хэрэгсэл бэлэглэснээс орчин үеийн баргаат замын машин нь хууль бус ан агнууртай тэмцэхэд, УАЗ фургон нь эрдэм шинжилгээ, судалгааны ажилд, трактор нь хүнд хэцүү нөхцөлд ялангуяа өвлийн улиралд ашиглагдаж байна.

Алтын дала БНГ нь мөн нэмэлт тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Жишээлбэл хамгаалалтын захиргаанд судалгааны ажилд зориулан компьютер өгсөнөөс гадна байгаль хамгаалагчдыг GPS болон дурангаар бүрэн хангасан. Цаашилбал байгаль хамгаалагчид болон



Зургийг КБТЗХН

Алтын Дала БНГ-ын шинжлэх ухааны хэлтэст ГМС-ийн сургалт явагдаж байгаа нь.

багт зориулсан хэд хэдэн удаагийн сургалтыг хийсэн. Байгаль хамгаалагчид GPS болон газрын зургийг ашиглахад суралцан, онолын болон дадлага ажлыг хийсэн байна. Зэрлэг ан амьтдын мониторинг, трансектын тооллого, хээрийн нөхцөлд хэрхэн ажиллах талаарх өөр нэгэн сургалт хийгдсэн.

Нэмж хэлэхэд эрдэм шинжилгээний хэлтэс нь өөрсдийн хамгаалалттай нутгийн зургийг гаргах боломжтой ГМС-ийн үндсэн тоног төхөөрөмжөөр хангагдсан.

Энэхүү хөтөлбөр нь КБТЗХН-ийн хамтрагч Грегор Луйзадерийн хүрээлэн буй орчныг хамгаалах нийгэмлэг, Франкфуртын амьтан судлалын нийгэмлэгээс санхүүжиж байгаа бөгөөд 2014 оны туршид үргэлжлэх болно. Нэмэлт сургалтуудыг Соколовский-Сарбайское нийгэмлэг (Sokolovsko-Sarbaiskoye ore processing/production association) болон Евроазийн байгалийн нөөцийг хамгаалах нийгэмлэг хамтран санхүүжүүлсэн.



Зургийг КБТЗХН

Иргыз Тургай БНГ-т бэлэглэсэн хоёр шинэ машин.

Хүүхдийн тоглоомын түүх дэлхийг өөрчилж байна.

Виктор Григорьев, Гала-Фильм студи, mooglik@mail.ru

Узбекистаны Каракалпак тосгоны хүмүүсийн амьдрал соёлд бөхөн нь ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Бөхөн нь ардын үлгэр, домог, ба тал хээрийн ариун шүтээний нэгдмэл чанар, эрүүл энх, амжилт бүтээл, хангалуун байдлын билэгдсэн уламжлалт хатгамалд байсаар байна. Нукус дахь БХН-ийн Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубийнхэн бөхөнгийн тухай сүлд дуутай болох зорилгоор дуу бичүүлэх саналаа олны танил, залуу хөгжмийн зохиолч Коблан Эденбаевт ирүүлжээ. Кобланы зохиосон дуу 2013 оны Бөхөн хамгаалах фестивалийн үеэр олны хүртээл болсон. Лондонгийн Эзэн хааны коллежийн докторант оюутан Жое Булл энэ жил уг дууны англи хувилбарыг танилцуулсан бөгөөд БХН уг дуунд клип хийлгэхээр болжээ. Энэ үеэс бид оролцон, манай уран бүтээлчид клипний санааг гаргахаар ажиллаж эхлэсэн. Манай зураглаач, туслах найруулагч Александр Клепалов хөдөлгөөнт дүрс ашиглах саналыг дэвшүүлсэн. Бид эгч дүүсийн тоглож буй орчинд анхаарлаа хандуулан хүүхдийн тоглоомонд хандах өнцгөөс бөхөнг хайрлан хамгаалах санааг олж харав байв.



Зургийг Александр Клепалов

Жое Булл дуугаа бичүүлж байгаа нь.

байв. Удаан хугацаанд хайсны эцэст төмөр утсан хүрээнд шавар тогтоон хийхээр шийдсэн. Энэ нь хялбархан, хурдан, хамгийн үр дүнтэй боломж байсан бөгөөд биднээс урлагийн бүх авьяас, чадварыг шаардсан зүйл байв. Эцэст нь, бүх зүйл бэлэн болсон! Гала-Фильм студи биднийг гэрэл зургийн тоног төхөөрөмжөөр хангасан бөгөөд үүний төлөө студийн захирал Галина Виноградова-д талархаж байна.


Бидний ажлын хамгийн хүндрэлтэй зүйл нь хүүхдүүд зурганд орох үед тэдний хүсэл сонирхлыг удирдах явдал байсан. Гэсэн хэдий ч монтаж болон зарим нэг тусгай эффект оруулан 3 долоо хоногийн дараа клип бараг бэлэн болсон байв. Бид хүүхдийн тоглоомоор дамжуулан бөхөнгийн тухай сонирхолтой түүхийг дүрсэлж чадсан гэж бодож байна.

Охин болон хөвгүүний өгүүлж буй бөхөнд тулгарч буй бүх бэрхшээл, аюул занал бодит ертөнцөд байсаар байна.! Манай клипэнд хөвгүүн өөрийн буруугаа ухаарч буйг харуулсанчланбөхөнг алах нь ямар буруу зүйл болохыг хүмүүст ойлгуулахад туслах болно гэдэг би үнэхээр итгэлтэй байна. Ингэснээр ирээдүйд хээр талд бөхөнгийн сүргийг харах боломж олдох болно.

Энэ төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Хьюстон хотын амьтны хүрээлэнд талархаж байна. Клип 2014 оны 5 сард Бөхөн хамгаалах өдрөөр Каракалпак тосгонд болон Узбекистаны бөхөнгийн тархац нутагт байх тосгон бүрт, Нукус хотод олны хүртээл болсон. Уг клипний англи хувилбарыг

<https://www.youtube.com/watch?v=V0wF8KFmOAs>

болонКаракалпак дахь Кобланий оргинал хувилбарыг <http://www.saigaresourcecentre.com/videos/saiga-gimm-the-saiga-and-the-steppe/> хаягаар татан авах боломжтой.



Зургийг Виктор Григорьев

Хүүхдүүд бөхөнтэй тоглож байгаа нь

Эрэгтэй хүүхэд нь тоглоомон машин болон жижиг тоглоомон цэргээр байхад охин тоглоомон бөхөнгөөр тоглож байв. Хүүхдүүд өөрсдийн зан төрх, хувь тавиланг өөрсдийн тоглоомоор илтгэн харуулж байгаа жижиг бурхад мэт байсан. Энэхүү тоглоом нь дэлхий рүү хандсан хүүхдийн хандлагыг илтгэж байна.

Эрэгтэй хүүхэд хулгайн анчдын талд зогсон, бөхөнг буудаж, хулгайн анчид илгээн, хийн хоолой, төмөр зам зэрэг бодит саад хаалтыг барьж байв. Харин охин ахынхаа эсрэг зогсон тухайн амьтныг хамгаалах бүх боломжит арга замыг эрэлхийлж байна. Уг түүх харгис хэрцгий байдал, сайхан сэтгэл, найрсаг зан, бодлогогүй үйл ажиллагаа зэрэг өрсөлдөөнийг тойрон үргэлжилж байна. Эцсийн эцэст хүүхдүүдийн хоорондоо сөргөлдөж буй бодлууд өөрчлөгдөн, хэн хэн нь гэмгүй амьтдыг алсаны гэм бурууг ухаарч эхлэн, тэдгээрийн хамгаалахыг хүсэж байна.

Кино зохиол бичигдэн, гол дүрийн баатруудыг сонгон авсан. Долоон настай Рустам, 6 настай Сафина нар манай бөхөнгийн клипний гол дүрд тоглосон. Бидэнд хэрэгтэй тоглоомын ихэнх нь маш хялбархан олдсон бөгөөд харин бөхөнгийн барималолоход хүндрэлтэй

Бөхөнгийн өдөр-2014

Сүүлийн жилүүдэд бөхөнгийн тархац нутагт байх тосгодод Бөхөн хамгаалах өдрийг тэмдэглэн

Өнгөрүүлэх нь нэмэгдэж байна. Энэхүү арга хэмжээ бөхөн

төллөх үеэр буюу 4-р сарын сүүл, 5-р сарын эхээр зохион байгуулагдсан. Бөхөн хамгаалах өдрийн зорилго нь бөхөн хамгаалах талаарх олон нийтийн мэдээллийг сайжруулах, бөхөнд тулгарч буй аюул заналд залуу үеийн анхаарлыг хандуулах зэрэг болно. Энэхүү наадмыг олон улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион явуулсан. 2014 оны Бөхөн хамгаалах өдрийг Ховордсон зүйлийг хамгаалах олон улсын сан, the Coins for Change, Дисней Канада, Диснейн олон улсын хамгааллын сан ивээн тэтгэсэн

Халимагийн Бөхөн хамгаалах өдөр

Айгул Айтбаева, Халимагийн Зэрлэг амьтан хамгаалах төв, saiga-center@mail.ru

Бөхөн хамгаалах өдөр нь Халимагийн Яшкул болон Черноземел дүүрэгт 4 сард болсон. Эдгээр нь Халимагийн бөхөнгийн тархац нутгийн үндсэн хэсэг учраас “Амьд өв” (Яшкул тосгон) ба “Бамба Цэц” (Адык тосгон) тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клуб 2013 онд байгуулагдсан. Эдгээр клубууд нь энэ жилийн Бөхөн хамгаалах өдрийг зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн.

Зургаан сургуулийн бүх насны хүүхдүүд Яшкул тосгонд зохион байгуулагдсан баярт уригдсан. Халимагийн БНУ-ын Байгалийн нөөц, хүрээлэн буй орчны яам, Боловсрол шинжлэх ухааны яамны төлөөлөл, Зэрлэг амьтан хамгаалах төв, Халимагийн Улсын их сургуулийн ажилтнууд мөн урилгаар оролцсон. Англи болон Казахстаны зочид уг баярын арга хэмжээнд оролцов.

Аливаа чухал үйл ажиллагааны өмнө болдог Халимагийн уламжлалт ёслолоор Бөхөн хамгаалах өдөр эхэлсэн. “Коевал” хүүхдийн клубийн гишүүд ус, дэлхий, агаар, гал гэсэн 4 махбодийг бишрэн шүтэх зан үйлийг харуулсан. Тэдний тоглолт байгаль, түүнд амьдрах бүх зүйл, ялангуяа бөхөнд хүндэтгэл үзүүлдэг Халимагийн уламжлалт ёсыг хадгалан үлдэхийн ач холбогдлыг илүү тодорхой харуулсан.

“Амьд өв” клубийн гишүүдийн бэлтгэсэн “Бөхөнгийн янзага нар луу ниссэн нь” тоглолт үзэгчдийн сонирхлыг ихээхэн татаж байв. “Экос” клубийн гишүүд сүүлийн 30 жилийн хугацаан дахь бөхөнгийн тоо толгойн өөрчлөлтөнд анхаарлыг нь хандуулан, бөхөнд тулгарч буй аюул занал, тэдгээрийн хамгаалалд оруулж буй хувь нэмэр



Зургаа Айгул Айтбаева

Адык дунд сургууль дээр болсон зурагт үзүүлэн

зэргийг эргэн дурсахыг үзэгчдэд уриалсан.

Бөхөн хамгаалах өдрийн хоёр дахь хэсэг нь “Хүрээлэн буй орчны экспресс-байгальтай найз болцгооё” нэртэйгээр Яруу найраг, Хөгжим, Ерөнхий мэдлэг, Зураг гэсэн 4 өртөө тус бүрт айлчлал хийхээс бүрдэж байв. Залуучууд Халимагийн байгаль, тэдгээрийн хамгааллын талаарх сайн мэдлэгтэйгээ харуулсан бөгөөд тэд шүлэг, зурагт үзүүлэн зохиож, бөхөнгийн тухай уриа хийсэн.

Бид “Намайг хайрла, хүмүүсээ” сэдвийн хүрээнд хийгдсэн зурагт хуудасны уралдааны үр дүнг танилцуулсан. Сургуулийн хүүхдүүд бөхөнг хайрлан хамгаалах, хүмүүсийн өөрсдийн гараар тэднийг устгаж буй сэтгэл түгшээсэн үйлдлийг дүрслэн харуулсан. “Амьд өв” клубийн гишүүд өөрсдийн хийсэн мэдээллийн зурагт хуудсыг байршуулсан байв.

Адык дунд сургуульд мөн бөхөн хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд Яшкул, Сарул сургуулийн олон залуу байгаль хамгаалагч хүүхдүүд уг үйл ажиллагаанд оролцсон. Багачууд “Форт бойард” нэртэй тоглоомыг ихээхэн анхааралтайгаар тоглож, “Бамб Цэц” клубийн гишүүд “Бөхөн хээр талын үзэсгэлэн гоо” нэртэй концерт тоглосон. Сэтгэлд хоногшсон олон мөчүүдийн нэг нь Халимагийн БНУ-ын соёлын гавъяат ажилтан, яруу найрагч Грегорий Кукарекагийн тоглолт байсан.

Тэрээр энэхүү боломжийг ашиглан бөхөнгийн тухай шүлгээ уншсан.



Зургаа Айгул Айтбаева

Бөхөнгийн өдөрт зориулсан Халимаг бүжиг

Энэ жил анх удаагаа багш нар болон эцэг эхчүүд хамтдаа бидний үйл ажиллагаанд оролцсоныг дурдахад таатай байна. Энэ өдрийн туршид Технологийн багш Владимир Бьорчиев болон “Бамб Цэц” клубийн гишүүд бөхөнгийн бэлэг дурсгалыг модоор сийлбэрлэн хийж байв.

Хамгийн сүүлд, Яшкул тосгоноос ирсэн клубийн сурагчид хүүхдүүд болон насанд хүрэгчид оролцон амилуулсан “Бөхөнг хамгаалъя” нэртэй жүжиг тавьсан.

Нэмж хэлэхэд, Яшкул болон Адык тосгоны бөхөн хамгаалах өдөрт хүрэлцэн ирсэн Зэрлэг амьтан хамгаалах төвийн ажилтан хүүхдүүдэд лекц уншсан бөгөөд бөхөнг ойроос харах боломжийг олгон Яшкулийн бөхөн үржүүлгийн төв рүү аялал зохион байгуулсан. Мөн “Бөхөн” буухиа уралдаан Цэлин дүүргийн Тройт сургуулийн өсвөрийн сурагчдын дунд зохиогдсон.

Бидний энэхүү амжилттай үйл ажиллагаа нь ойрын



Зургийг Аюул Алтбаева

Адык дээд сургууль дахь бөхөнгийн өдөр.

ирээдүйд тал нутагт бөхөнгүүд олноороо сүрэглэн, бидний хамтын үр бүтээмж өнгөц зүйл биш байх итгэлийг өгсөн.

Узбекистаны Бөхөн хамгаалах өдрийн цар хүрээ өссөөр л байна.

Наталья Шивалдова, ЭкомактабТББ, nshivaldova@mail.ru

Бөхөн хамгаалах өдөр нь Устюртын тал нутгийн алслагдсан тосгодод найман жилийн турш Байгаль хамгаалах төрийн зөвлөл, Нэгдсэн улсын хүүхдийн аялал жуулчлалын зөвлөл, Бүс нутгийн Экологийн судалгааны төвийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж байна. Үйл ажиллагааг Боловсролын яамны нөөц сангаас ивээн тэтгэдэг. Өнгөрсөн 4 сард болсон Бөхөн хамгаалах өдрийг ивээн тэтгэсэн эдгээр байгууллага бидэнтэй хамтран тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубийн удирдагч, сургуулийн багш нартай богино хугацааны хурал хийн, фестивалаас олж авсан туршлага, хэрхэн энэхүү үйл ажиллагааг сайжруулах, хэрхэн нөхөрлөлийн гишүүдийг өргөн хүрээтэй оролцуулах талаар хэлэлцсэн.

Энэ жилийн хөтөлбөрт олон нийтлэг уралдаан тэмцээн, мөн “Экологийн галт тэрэг” гэсэн олон ялгаатай нэрээр нэрлэгдсэн өртөө бүхий тэмцээнийг нэмж оруулсан.

Үндэсний уламжлал өртөө нь үзэгчдэд ихээхэн танил байсан бөгөөд энэ жил хүүхдүүд нишингийн дэвсгэр нэхэх, тэмээний ноосоор зузаан эсгий хийх зэргийг хэрхэн сурсанаа харуулсан. Энэхүү өртөөний ач холбогдолтой тал нь залуу үе үндэсний уламжлалыг хадгалсаар байгаа өөрсдийн эцэг эх, өвөө, эмээгийн дэмжлэг, зөвлөгөөг авахаар тэмүүлж буйд оршино. Ийм замаар Бөхөн хамгаалах өдөр нь хүмүүсийн хоорондох харилцааг сэргээн, хүчирхэгжүүлж, мартагдаж буй үндэсний уламжлал, гар урлалыг сэргээх явдал юм.

Жаслык тосгоны, цар хүрээ нь өргөжсөөр байгаа уг наадмын өөр нэгэн шинэлэг тал нь сургуулийн багш нарын баг хүүхдүүдийн багийн өрсөлдөгч болон тэмцээнд идэвхтэйгээр оролцсон.

54-р сургууль дээр зохиогдсон “Бөхөн хамгаалагч” холын зайн гүйлт нь ихээхэн сонирхол татаж байв. Энэ санааг “Акбокен” зэрлэг амьтдыг хамгаалах клубын гишүүд, ахлах ангийн сурагчид санаачилсан. Аагим халуун наранд талд гүйж байгаа бөхөн юу мэдэрдэг талаарх анхан шатны мэдлэгийг олж авахаар шийдвэрлэжээ. Тиймээс зохион байгуулагчид уралдаанд оролцож буй хүүхдүүдийн аюулгүй байдлыг харгалзан үзсэн. Зам дагуу уух усыг ширээн дээр тавьсан байсан бөгөөд гүйж байгаа хүмүүсийг эмнэлгийн машин дагалдан явж байв.

Гүйгчид уралдааны замаас гарч болох



Зургийг Наталья Шивалдова

Кырк-кыз тосгон. Экологийн галт тэрэг, Үндэсний уламжлал өртөө.

байсан хэдий ч бүгд маш их идэвхтэй, үнэнчээр оролцсон. Эцсийн мөчид багийнхан бүгдээрээ барианы шугаманд хүрч чадсан... Энэхүү холын зайн гүйлт нь оролцогчид өөрсдийн сэтгэгдлээ хуваалцсанаар үргэлжилсэн бөгөөд хүн бүрт хээр талыг хөндлөн туулах бөхөнтэй ижил төстэй байснаар төсөөлөгдсөн байна. Ингэснээр хүүхдүүд бөхөнг хамгийн сайнаар ойлгож авахад тусалсан бөгөөд байгаль дэлхийн энэхүү гайхалтай бүтээлийг хүндлэх тэдний хүндлэлийг нэмэгдүүлсэн. Нар шингэж, өдрийн халуун буурах үед Жаслыкын оршин суугчид (хүүхдүүд, эцэг эх, багш нар, хийн компаний ажилчид, цагдаа, тосгоны хөгшид бүгд) задгай талбай руу гарцгаав. Хөгжмийн аянд уралдааны ялагчид шагнал гардуулах ёслол боллоо. Тосгоны ахлагч-нөхөрлөлийн зөвлөлийн дарга, сургуулийн захирал, хөгшид шагнал гардуулах ажиллагаанд маш их ач холбогдол өгөн оролцсон. Жаслык тосгоны уг хөтөлбөр цэцэрлэгийн хүүхдүүдийн оролцсон бяцхан бөхөнгийн бүжгээр өндөрлөсөн.



Зургийг Намалъя Шивалова

Кырк-кыз тосгоноос ирсэн бяцхан бүжигчид.

ховор амьтныг хайрлан хамгаалж чадна. Мөн бид тэднийг илүү их хамгаалж, хайрласнаар бөхөнд хандах хүмүүсийн хандлагыг өөрчилж чадна” гэж хариулсан юм.

Кырк-кыз тосгоны Бөхөн хамгаалах өдөр “Ногоон эргүүл” зэрлэг амьтан хамгаалах клубийн гишүүд гар гараасаа барин өөрсдийн төрөлх хэл дээр бөхөнгийн тухай магтаалыг дуулснаар эхэлсэн. Хурлын заал бөхөнгийн талаарх үндсэн сэдэв бүхий зураг, үзүүлэн, гар урлалын галерей болон хувирсан байв. Бөхөнг дүрслэн үзүүлэхэд ашигласан урлалын төрлүүд олон янз, тухайлбал, уран хатгамал, үр, баримлын шавар, шилээр хийсэн мозайк, зурагт ном зэрэг нь бүгд хүүхдүүдийн гараар бөхөнтэй нь үнэхээр гайхалтай байв. Хүүхэд бүрийнх ялгаатай байв. Нэгдүгээр үзэгдэл нь өвсөн дунд аав, ээж нь янзагануудтайгаа тоглон наадаж буй бөхөнгийн сүргийг харуулсан бол хоёрдугаар үзэгдэлд: буутай хүнийг томруулан харуулж, янзагаа хамгаалан өндийсөн эр бөхөнг буудан хөнөөж буйг, гуравдугаар үзэгдэлд: нялх янзаганууд эхийнхээ хамгаалалтанд өсөн хулгайн анчид руу өөрсдийн бяцхан эврээ чиглүүлж буйг, анчид зорьсоноосоо буцан ухарч буйг тус тус харуулжээ. Миний бие энэхүү бяцхан үзвэрүүдийг үзэж явахдаа жүжигчдээс үзэгчид рүү харцаа шилжүүлэн харж байв. Зарим нэг нь “амаа ангайн”, нулимсаа арчин суугаа насанд хүрэгчид нүдээ жүжигчдээс салгаж чадахгүй байв.

Ахлах сурагчдын сэтгэл хөдлөл сүүл рүүгээ маш их болсон байв... Тэд нүдээ салгалгүй гөлрөн ширтэж, эр хүн уйлах нь зохимжгүй тул нүдэн дээрээ гялалзан гарч ирэх нулимсаа буцаан барьж байв. Энэ нь “урлагийн хүч ” юу хийж чадах болон уг үйл ажиллагаагаар дамжуулан олгох боловсролсургуулийн ердийн хичээлээс 10 дахин хүчтэй нөлөөтэй байж болохыг харуулсан.

Жижиглэн хуваасан шоогоор бөхөнг бүтээх “Өөрийнхөө бөхөнг бүтээ” уралдаан биднийг маш их гайхашруулсан. Нүдээ боосон хүүхдүүд шоог эвлүүлж байв. Хамгийн хурдан бөгөөд зөв шоог эвлүүлсэн нь ялагч болж байсан. Бяцхан бөхөнгийн тухай сэтгэл догдлом, чин сэтгэлээсээ хийж буй балет, шилэн сувс, зузаан эсгий, сүрэл ашиглан бөхөнг дүрсэлсэн зураг, гар урлалын бүтээлээр дүүрсэн гайхалтай урлан зэргийг бид мөн



Зургийг Намалъя Шивалова

Жаслык тосгоны Бөхөн хөл бөмбөгийн цомын ялагчид.

Хөгжим зогсож, зочид гэрлүүгээ явцгаах үед ахлах сургуулийн дэд захирал Садырбай Шайменовтай уулзаж, Бөхөн хамгаалах өдөр түүнд ямар санагдсан талаар асуув. Тэрээр: “Энэ бол манай сургуулийн төдийгүй манай тосгоны хувьд чухал үйл явдал юм. Бид үүнд маш хариуцлагатай, бүтээлчээр хандсан. Энэ жил манай сургуулийн бүх багш нар энэ наадамд бэлтгэхэд бидэнд тусаллаа. Хүн болгон бөхөн хамгаалалд оруулж буй бидний хувь нэмэр гэж ойлгож байна. Бид юу хийж чадах вэ? Бид өөрсдийн байгаль дэлхийгээ, энэхүү



Зургийг Намалъя Шивалова

Нукус хотын Бөхөн хамгаалах өдөрт оролцогсод.

харсан. Гэсэн хэдий ч наадмын оргил цэг нь Каракалпакын нэрт дуучин, хөгжмийн зохиолч Коблан Эденбаевын дэвшүүлсэн ая дууны мэндчилгээ, Бөхөн хамгаалах өдөрт зориулан Гала-Фильм студийн бүтээсэн кино байсан (дээрээс хар).

Бүх хүүхдүүд гар гараасаа барилцан видеон дээрх дуучныг даган дуулж байв. Уг арга хэмжээ дууссаны дараа би уг наадмыг зохион байгуулсан, 31-р сургуулийн хамгааллын клубыг удирддаг Нашиба Абдраманова, Нигора Наримбетова хоёр Залуу багштай ярилцсан. Миний анхны асуулт бүх үзэгчдийг гайхшруулсан бяцхан бөхөнгийн тухай өгүүлсэн жүжгийн талаар байв: "Хэн энэ жүжгийг найруулсан бэ?" "Бид хамтдаа, насанд хүрэгчид, хүүхдүүд хамтран найруулсан. Бид хувцсыг хийж, жүжгийг хамтран дэглэсэн". "Яагаад бөхөнгүүд анчдаас өөрсдийгөө хамгаалах ёстой юм бэ?" "Үүний тухай маш их маргаан дэгдсэн" гэж Нигора Наримбетова хариулаад "гэвч буутай хүний өмнө бөхөнгүүд хэрхэн хүч дорой болдогыг бид харуулах хэрэгтэй. Сул дорой амьтдыг алахаар тал руу явж буй тэдгээр хүмүүс ичих ёстой гэж хүүхдүүд шийдсэн" гэлээ. Үнэхээр "хүүхдүүд үнэн үг хэлдэг" аж...



Зургийг: Наталья Шивалова

Бөхөнгийн нүүдэл тоглоомын эхлэхийн өмнө

Энэ жилийн наадам тэр чигтээ солонгын долоон өнгө шиг байв; зарим газарт илүү их сэтгэл хөдлөлийг авчирсан бол нөгөө нь хөл хөдөлгөөн ихтэй, заримд нь илүү нухацтай алсыг харсан гэх мэт.

Гэвч энэхүү үйл ажиллагаа бүхэлдээ биднээс хамгаалал болоод ухаарлыг шаардсан гайхалтай, үзэсгэлэнтэй байгаль дэлхий рүү орох хаалгыг онгойлгож өгсөн.

Монголын бөхөнгийн анчдыг шийтгэв.

Б. Чимэддорж, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, chimeddorj@wwf.mn

Энэ жилийн 1 сарын 22-нд Говь-алтай аймгийн Хөхморьт сумын Товгор гэдэг газарт Монгол бөхөнг хууль бусаар агнасан хэрэг гарсан. Уг хэргийг хууль бус антай тэмцэх "Ирвэс-3" баг, Бөхөн хамгаалагчдын сүлжээ, Говь-Алтай аймгийн Цагдаагийн хэлтэсийн хамтарсан мөрдлөг, шалгалтаар маш богино хугацаанд илрүүлэв. Шүүх хуралдаан саяхан болж, гэм буруутай нь тогтоогдсон хүнд хуулийн дагуу ял оноожээ. Энэхүү байж боломгүй хэргийг үйлдсэн Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын иргэн А.Ганпүрэвт шүүхээс 3 жил 10 хоногийн хорих ял төлөвлөжээ.

Шүүх хуралдаанд Хөхморьт сумын ард иргэд оролцсон. Өмнө нь дурдсанчлан хууль бус ангийн шалтгааныг тогтоох нээлттэй шүүх хурал Шарга, Төгрөг суманд болсон. Байгаль болоод зэрлэг ан амьтдыг хамгаалал хүн бүрийн анхаарлын төвд байна. Эх болсон байгаль дэлхийгээс хууль бусаар ан хийхийг оролддог шунахай хүмүүс байгаа нь харамсалтай юм.

Энэ хэрэг шиг олон нийтэд нээлттэй шүүх хурлыг зохион байгуулсан нь хууль бус ан агнуур хийгчдийн аливаа гэмт үйлдэлд ял шийтгэл ноогдуулдаг тодорхой дохиог өгсөнөөрөө ийм хэргийг багасгахад туслах юм.



Зургийг: Г. Олонбатмар

Хураагдсан амьтны гаралтай түүхий эд.

Бөхөн нөөцийн төвийн мэдээ

Лийжах Дорвард&Петер Дамарелл, БХН, www.saigaresourcecentre.com

Бөхөнгийн нөөцийн төв нь (SRC) дэлхий даяарх бөхөн хамгааллын цахим сүлжээг үүсгэх зорилгын хүрээнд мэдээллийн санг сайжруулах үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна. Вэб хуудсанд бөхөн хамгаалалтай холбогдох олон нийтэд нээлттэй зураг, видео бичлэг, уран зохиол, бөхөн хамгаалах боловсролын мэдээллийн нөөц өргөн цар хүрээтэйгээр, өсөн нэмэгдэж байна. Энд бөхөн судалдаг, байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг хүмүүсийн талаарх “Судлаачдын танилцуулга”, одоо хэрэгжиж буй бөхөн хамгааллын янз бүрийн төслүүдийн талаарх “Төслийн танилцуулга” хэсгүүд мөн байгаа. Эдгээр судлаачид болон төслийн талаарх танилцуулга нь дэлхийн өнцөг булан бүрт явагдаж буй судалгааны ажлын талаарх мэдээллийг солилцоход туслах, мөн бөхөн хамгаалагчдыг ижил газар нутагт, ижил төсөлд ажиллаж буй хүмүүстэй холбогдоход туслах болно.

Бөхөнгийн нөөцийн төвд одоо хийгдэж буй ажил нь Орос, Хятад, Казах хэлээр ярьдаг хүмүүст илүү хүртээмжтэй болгохын тулд англи бус хуудсыг сайжруулахад чиглэгдэж байна. Бид мөн англи хэлээр бус өөр хэл дээрх ном зохиолын томоохон хэмжээтэй номын санг татаж авах болон тодорхой мэдээллийг хайхад хялбар болгох

зорилгоор ном зохиолын хэсгийг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Уг цахим хуудасны форум дэлхийн өнцөг булан бүр дэхь бөхөн судлаач, хамгаалагчдын хоорондох харилцаа холбоо, хэлэлцүүлгийг өрнүүлэхэд бараг бэлэн болоод байна.

Хэрвээ та бөхөнгийн судалгаа болон хамгааллын асуудал дээр ажилладаг бол гишүүн болж, өөрийн хувийн туршлага, төслийн танилцуулгаа Бөхөнгийн нөөцийн төв рүү хандан илгээнэ үү.

Цахим хуудсанд олон бөхөн судлаач, хамгаалагчдыг нэгтгэснээр дэхийн өнцөг булан бүрт байгаль хамгааллын ажил эрхлэгчдийн хүчирхэг сүлжээг үүсгэж чадна. Бөхөнгийн нөөцийн төвийн гишүүн болохын тулд өөрийн бүтэн нэрээ бичин saigaresourcecentre@gmail.com руу майл илгээн та цахим хуудсанд нэвтрэх хэрэглэгчийн нэр болон нууц үгийг өгөх болно.

Энэхүү хэрэглэгчийн нэр, нууц үг нь цахим хуудасны Мэргэжилтний нөөцөд нэвтрэн орох боломжийг өгөх бөгөөд (<http://www.saigaresourcecentre.com/specialist-resources/>), энд та өөрийн нарийвчилсан мэдээлэл, таны оролцож байсан бөхөнгийн төслийн талаарх танилцуулгыг нэмж чадна.

Хэвлэлийн мэдээ

Степной БНГ бөхөнд зориулан “төллөх үеийн асрамжлан хамгаалах” газрыг бий болгов.

ОХУ-ын Астрахан мужийн Лиман дүүргийн Степной БНГ-т жилийн туршид бөхөнг харж болно. Сүүлийн хэдэн жилийн туршид тухайн БНГ-т төллөдөг болоод байна. Энэ жил Астрахан мужийн Байгалийн менежмент болон хүрээлэн буй орчныг хамгаалах хэлтэс болон Степной БНГ-ын менежерүүд төллөж буй сүргийг тойрон өдөр шөнөгүй хамгаалж байхаар шийдвэрлэсэн. Бөхөнгийн “төллөх үеийн асрамжлан хамгаалах” газрыг тодруулан, тухайн газар руу орохыг хориглосон тэмдгийг босгосон. Өмнөх үнэлгээнээс харвал төллөх үеийн сүрэг 3-3,5 мянган бодгалиас бүрдэж байна. Төллөж буй бүсээс янзагатай шаргачингууд тэнэж эхлэх

үед Степной БНГ-ын хил хүртэл ТХН-ийн хилийг өргөтгөхөөр шийдвэрлэсэн. Лиман дүүргийн цагдаа бөхөнг өдөр шөнөгүй хамгаалахад нөөц газрын байцаагч нарт тусладаг байна. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <http://nat.astrobl.ru/pressrelease/otel-saygaka-na-territorii-zakaznika-stepnoyastrahanskoy-oblasti> хаягаар хандан авна уу.

Редакцийн зөвлөлөөс: Астрахан мужийн захиргаа 6 сарын 5-нд болсон экологичдын өдрийг тохиолдуулан Степной БНГ-ын дарга Владимир Калмыковыг бөхөн хамгааллын үйл ажиллагаанд түүний гаргасан зүтгэл, гавъяаг үнэлэн шагнасан. Энэхүү нэр хүндтэй шагнал авсан явдалд баяр хүргэе.

Казахстаны бөхөнгийн популяци 3 дахин өсчээ.

2014 хавар гүйцэтгэсэн агаарын тооллогын үр дүнгээс Казахстаны бөхөнгийн тоо толгойг үнэлэн үзвэл түүний хамгааллын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх боломжтой. Уг агаарын судалгааг Казахстаны амьтны аймгийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах үндэсний хөтөлбөрөөс хэрэгжүүлэн 2014 оны 4 сарын 9-нөөс 5 сарын 1 хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн бөгөөд КБТЗХН, Охотзоопромын төвийн болон бүс нутгийн салбарын ажилтнууд оролцсон.

Судалгааны баг Казахстаны 3 бөхөнгийн популяцийн тархац нутгийг, тухайлбал Бетпақдала (Караганда, Костанай муж); Устюрт (Актюбинск); Урал (Баруун



Зурагийг Евгений Попанский

Дөнгөж төрсөн янзага.

Казахстан муж) хамруулан 230 цагийн нислэг гүйэтгэжээ. Бөхөнгийн тоо толгой өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 37 хувиар нэмэгдэж нийтдээ 256000 толгой болжээ. Бөхөнгийн хамгийн бага тоо 2003 онд ердөө 21000 толгой хэмээн тоологджээ. *Илүү дэлгэрэнгүй*

<http://www.newskaz.ru/society/20140613/6604841.html>

болон

http://www.kazakhzerno.kz/index.php?option=com_content&task=view&id=92273&Itemid=108 линкээр

авч болно.

Казахстанд хууль бус бөхөнгийн агнуур зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдлоо.

Казахстаны Кызылорда мужийн прокурорын байгууллагын мэдээллээс үзвэл 2014 он гарснаас хойш бөхөнгийн хууль бус агнуурын 2 удаагийн үйлдлээр 20 бодгалийг алж, эврийг хөрөөдөн авсан байна.

Прокурорын газар Кызылорда мужид бөхөнгийн хууль бус агнуурыг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл үйлдэж байгааг цохон тэмдэглэжээ. Бөхөнг агнаж буй хэрэгтнүүд 3 дамжлагатай байх ба нэг бүлэг нь бөхөнг бууддаг бол, нөгөөх нь эврийг нь хөрөөдөн цуглуулдаг, гуравдах нь тэдгээрийг гадаад руу гарган зардаг байх жишээтэй.

Прокурорын газраас бөхөнг хамгаалахын тулд Алматы болон Хятад руу эвэр зөөн борлуулдаг сувгийг хаах хэрэгтэйг сануулсан. Бөхөнгийн эврийн анчид ганцаараа эдгээрийг хийдэггүй болохын бодит жишээ нь тэд маш сайн тоноглогдсон, бартаат замын машиныг ашигладаг учраас байгаль хамгаалагчид тэднийг барьж авах боломж тэр болгон байдаггүй.

Хулгайн анчид өөрсдийн танилууддаа болон зах дээр бөхөнгийн махыг үхэр, адуу, хонины махны нэрээр зардаг байж болзошгүй болохыг прокурорын байгууллага сануулсан. Гэхдээ бөхөнгийн махыг авах зорилгоор хууль бус ан хийгчид сайн тоноглогдсон бөхөнгийн эврийг цуглуулдаг анчид шиг үргэлж агнадаггүй бөгөөд тэдний зарим нь мотоцикл унан өвлийн улиралд ан хийхээр явдаг байна. *Илүү дэлгэрэнгүй*

http://kazakhzerno.kz/index.php?option=com_content&task=view&id=88400&Itemid=108 хаягаар хандан авна уу.

Хууль бусаар хил давуулж буй бөхөнгийн эврийг илрүүлэхэд үнэрч нохойг ашиглаж байна.

Алматы хотноо Казахстаны БНУ-ын Сангийн яамны Гаалийн хяналтын зөвлөлийн бүс нутгийн нохой сургалтын төвд 4 сарын сүүлээр дөрвөн үнэрч нохой болон тэдгээрийн сургагч нарт бөхөнгийн эвэр илрүүлэх сургалтыг эхлүүлсэн. Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, Их Британид төвтэй ТББ болох Олон улсын амьтан ургамал хамгаалах



Зурагийг Карлынаш Масатова

Бүрэн сургагдсан бөхөнгийн эвэр илрүүлэх сургалтын хөтөлбөрийг шинээр дүүргэгчид одоо ажилдаа бэлэн байна.

Узбекистанд бөхөнгийн зурагтай марк хэвлэгдэн гарлаа

Узбекистаны Төв шуудангийн газар Узбекистаны Улаан дансанд бүртгэгдсэн, ховор ан амьтдыг дүрсэлсэн маркны цувралыг хэвлүүлэн гаргажээ. Гурван маркнаас бүрдэх уг цувралын нэгэнд бөхөнг дүрслэн харуулжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://peterstamps.ru/news/2091>, <http://infocom.uz/2014/06/05/vypushhena-novaya-seriya-pochtovyx-marok-faunaredkie-zhivotnye-uzbekistana/> холбоосоор орж харна уу.



ӨГҮҮЛЭЛ

Хамтдаа зурав—Узбекистаны хүмүүс болоод ан амьтад

Рори Мас Канн, www.rorymccannmurals.com

mccannmurals.com

Олга Есипова, esipovaolya@gmail.com

Энэ хавар Узбекистанд бөхөн хамгаалах шинэ хандлагыг бараг бүрэн эхлүүлсэн. Их Британий зэрлэг ан амьтны зураач Рори Мас Канн тал хээрийн зэрлэг ан амьтныг хананд буулган зурахаар Каракалпакстан руу аялсан. Узбекийн залуу бөхөн хамгаалагч Олга Есипова Рорид орчуулга болон зураг зурахад нь тусалж байсан. Энэ санаа нь орон нутгийн хүүхэд багачуудын оролцоотойгоор ханын зураг бүтээснээр бөхөн хамгааллын талаарх мэдлэгийг өсгөх зорилготой байсан. Бүс нутгийн нэг сургууль дээр олон сурагчид оролцон ханын зураг зурсан. Энэ төсөл нь дэлхий дээрх бүх хамгааллын ажлыг санхүүжүүлж буй Дисней Канада болон **Coins for Change** хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн.

“Бөхөнг дүрсэлсэн ханын зураг нь үгээр илэрхийлэхийн аргагүй, үнэхээр гайхамшигтай. Манай сургууль таны энэхүү гайхалтай бүтээлийг талархан хүлээн авлаа. Рори бол үнэхээр гайхалтай зураач, өөрийн зургаа сэтгэлээрээ зурдаг! Хэдийгээр Олга өөрийн хамгааллын ажлаа дөнгөж эхэлж байгаа боловч тэр маш их зүйлийг аль хэдийн хийсэн. Би түүнийг удалгүй оргилд нь хүрэх болно гэдэгт итгэлтэй байна! Таны бүтээлээс хүмүүст өгч буй тааламжит мэдрэмж, таны хичээл зүтгэлийн аль алинд нь танд маш их талархаж байна. Таны зураг үгнээс илүү үнэ цэнэтэй!”

- Айсулу Долдашбаева, Нукус, 37-р сургууль

Рори Мас Канн: Би Их Британий зэрлэг амьтдын зураач, ихэвчлэн сургуулийн томоохон хэмжээтэй урлагийн бүтээл дээр ажиллаж байна. Би Австрали,

Сейшелийн арлууд, Оман, Японд зураачаар ажиллаж байсан. Узбекистанд ирсэн бидний зорилго нь орон нутгийн сургуулийн хүүхдүүдтэй хамтран ажиллаж, Тал хээрийн зэрлэг ан амьтдыг дүрсэлсэн том хэмжээтэй зураг зурах явдал байв. Энэ нь орон нутгийн хамгааллын үр нөлөөг дээшлүүлэхэд ялангуяа бөхөн рүү чиглэсэн тэдний хандлагыг сайжруулахад туслана гэдэгт бид итгэсэн.

Энэ бүхнийг эхлүүлэх энэхүү төслийг амжилттай хэрэгжив. Бидний зорилго бол тухайн нутгийн зэрлэг ан амьтад, тэдгээрийн хамгааллын үр нөлөөг тэдний сонирхлоор дамжуулан бий болгох, хүүхдүүдийг оролцуулан ханын зураг зурах явдал байв. Хүүхдүүд бидний үйл ажиллагааг шалгахад бөөн бөөнөөрөө тогтмол ирдэг байсан учир тодорхой хүчин чармайлт ороогүй. Бид өөрсдийнх байгаль дэлхийн үнэт баялгийн талаар тэдэнд ярихад ихээхэн анхааралтайгаар сонсож, өргөн уудам дэлхий ертөнцийн тухай улам их зүйлийг мэдэхийн тулд сонууч зандаа

хөтлөгдөж байв. Тэд ээлж дараалан зураг авахыг хүсч, гарын үсгээ зурсан жижиг хайчилбар хүсдэг



Рори Мас Канн –Их Британиас ирсэн зэрлэг ан амьтан зураач,



Рори Мак Канн болон Олга Есипова нар Нукус хотын 37-р сургуулийн сурагчидтай хамт.

авахыг хүсч, гарын үсгээ зурсан жижиг хайчилбар хүсдэг хэдий ч үүнээс илүүтэйгээр тэд асуулт асуухыг хүсэж байсан. Хүүхдүүд энэ насан дээрээ гайхалтай идэвхтэй, сониуч зантай байдаг учраас энэ нь миний сэтгэлийг догдлуулж байсан бөгөөд тэдний сонирхож буй биологийн олон янз байдал, хамгааллын талаарх тэдэнд ярьж өгөх гайхалтай цаг байв. Тэд хаана ч байлаа гэсэн хүрээлэн буй орчны асуудалд туслах чадвартай, томчуудын хүрээлэн буй орчны талаарх мэдлэгийг олж аван, итгэлтэйгээр манлайлах болно. Бид 8 өдрийн турш зураг зурсан. Бид тал хээрийн түлхүүр зүйл болох бөхөнг гол фокусаа болгон зурж эхэлсэн. Энэ үед бидэнтэй зэрэгцэн зураг зурахад олон хүүхдүүд оролцсон. Бид манай ажиглагчдаас үерлэн ирж буй асуултанд хариулахын зэрэгцээ тэдний зурах чармайлтыг зохицуулах боломжтой болсон. Нэмж хэлэхэд зураг зурахад оролцсон янз бүрийн насны хүүхдүүд биднийг тойрон өрөөнд шалавхан гэгч нь сууцгаан (заримдаа хананд будгийг хамаагүй будан) уламжлалт бүжгээ бүжиглэж өгдөг байв.

Миний ард үлдэж зураг мянга мянган залуусыг зэрлэг ан амьтны болон хамгааллын эерэг хандлагыг бий болгосоор байх ба олон жилийн туршид урам зоригийн эх үүсвэр, боловсролын хэрэглүүр болсоор байна гэдэг итгэлтэй байх болно. Надад Узбекийн тал нутгийн гайхалтай ан амьтдыг зурсан нь, санамсаргүй тохиолоор орон нутгийн хуримын ёслолын салшгүй хэсэг болсон нь, бүхнээс илүүтэйгээр Нукус дунд сургуулийн гайхалтай сурагчидтай харилцан ажиллаж байсан олон гайхалтай дурсамжууд сэтгэлд хоногшин үлджээ.



Хүүхдүүд бидэнтэй нэгдэв.

Бөхөн эсэн мэнд үлдэх итгэл найдвар тэдэнд эргэн ирж байна. Миний хувьд маш итгэлтэй байна. Энэхүү гайхалтай төсөл нь үүний нэг хэсэг юм. Е.Ж.Милнер Гулландад үр тариа тарин, түүнийг ургуулахад тусалсанд; Карлын Самуелд тодорхой мөртлөө төвөгтэй уг үйл ажиллагааг зохион байгуулсанд; Елена Быкова болон Александр Есипов нарын гайхалтай зочломтгой зан, хамтарч ажилласанд; Олга Есиповагийн гайхалтай зурах чадвар, бүрэн төгс орчуулга хийсэн болон сайн хамтрагч байсанд, Нукус хотын 37-р сургуулийн багш нар болон хүүхдүүдийн эелдэг зан, сониуч зан, урам зориг, инээмсэглэлд гүнээ талархаж байна.

Олга Есипова: Миний бие Узбекистанд Англи хэлний зүйн чиглэлээр суралцдаг, 18 настай оюутан. Сүүлийн хэдэн жилийн турш би Бөхөн хамгаалах нийгэмлэгт сайн дурын ажилтан хийж байгаагийн учир нь манай нутгийн зэрлэг ан амьтад намайг гайхашруулдаг бөгөөд миний хийж буй ажил хойч үеийнхний тусын тулд эдгээр амьтдыг хамгаалахад туслах болно гэж итгэдэгт оршино. Би урлагт сонирхолтойгоос гадна надад бага зэрэг зурах авьяас байдаг. Нукус дахь зургийн төсөлд оролцохдоо маш их урам зоригтой байсан ба надад олдсон гайхалтай боломж хэмээн маш их баярлаж байсан.



Рори Сургуулийн хүүхдүүдэд гитар тоглож өгч байна.

Би Нукус сургууль буцан очиж байсан агшнаа санаж байна. Сургууль миний төсөөлж байснаас илүү том болсон байсан бөгөөд-ойролцоогоор 2000 орчим сурагч энд суралцаж байгаа талаар хэлсэн. Хүн бүр биднийг харсандаа гайхаж байсан бөгөөд яагаад үл таних хүмүүс гэнэт гараад мэдэх нэг ч хүн байхгүй байв. Бид хүүхдийн оролцоогүйгээр хүрэх боломжгүй байсан асар том боломжит үр дүнг энэ төслөөс хүссэн. Иймээс хананд шууд зураг зурахын оронд эхний ээлжинд өөрсдийн төсөл, өөрсдийгөө танилцуулсан богино танилцуулгыг хийсэн. Энэ нь маш сайн ажил болсон. Биологийн төрөл зүйлийн талаарх илүү ихийг суралцах хүсэл тэдний сэтгэлийг гижигдэж байв. Тэд өөрсдөө оролцохыг хүсэж, олон асуултаар булж байв! Тэнд зүгээр суух ямар ч цаг зав байхгүй байсан. Удалгүй бид зурж эхэлсэн бөгөөд дараагийн өдөр нь цөөн хэдэн хүүхэд ирж бидэнтэй нэгдсэн. Би өмнө нь барзгар, тэгш бус гадаргатай ханан дээр зураг зурж буй хүүхэд хараагүй. Энэ нь эхэндээ жаахан тааламжгүй байсан хэдий ч илүү ихийг зурах тусмаа бид бүр их баяр хөөртэй болж байсан. Олон олон сургуулийн сурагчид, тэдний эцэг эх, багш нар бидэнд туслахаар эсвэл бидний зурсан амьтдыг харахаар ирдэг байв. Тэд бидэн дээр айлчлан ирэх бүртээ зэрлэг ан амьтан, хамгааллын үйл ажиллагааны талаар ямар нэгэн шинэ зүйл суралцаж

байсан. Нэг долоо хоног итгэхийн аргагүй хурдан өнгөрч, сургууль дээр өнгөрөөх бидний сүүлийн өдөр болсон байв. Бид бараг бүх цагаа зарцуулсан боловч сүүлдээ маш их шаргуу ажиллан, зургаа дуусгахыг хичээсэн.

Энэхүү төсөл амжилттай болсон. Тэдний сургуулийн нэг хэсэг болсон гайхалтай зургийг хараад хүүхдүүд сэтгэл хангалуун, баяр хөөртэй байгааг бид харсан.

Энэ зураг нь урлагт сонирхолтой болох, байгаль дэлхийг хайрлан хамгаалах урам зоригийг өгсөн. Уг төсөл хүүхдүүдийн бодол санаа, ойлголтын өөрчлөлтийг харуулах боломжийг олгон өөрчлөгдөж чадсанаараа надад маш их урам зориг өгдөг. Энэхүү амжилттай төслийн санааг орон нутгийн хүмүүсийн дундах бөхөнд хандах хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор бөхөн тархсан бусад нутагт хэрэгжүүлэх боломжтой гэдэгт би итгэдэг.

Би намайг энэ төсөл рүү оруулж, аян замын туршид цуцашгүй дэмжлэг үзүүлсэн аав ээж хоёртоо-Елена Быкова, Александр Есипов нарт, мөн гайхалтай багш, сайн найзын аль аль нь болсон Рори Мак Каннд асар их тэмүүлэлтэйгээр зургаа зурдаг болон гайхалтай гитар тоглодогт нь, сэтгэлт таатай дурсамж үлдээсэн,



Зургийг Александр Есипов

Бидний бүтээлийн нэр хүнд алгуурхнаар өссөөр д...

үнэлж баршгүй туслалцаа үзүүлсэн 37-р сургуулийн багш, хүүхдүүдэд талархлаа илэрхийлж байна.

Энэ ханын зурагны талаарх бичлэгийг

https://www.youtube.com/watch?v=v8up_3OQTkI

болон [https://www.youtube.com/watch?v=iqDhLVLhVG4&](https://www.youtube.com/watch?v=iqDhLVLhVG4&feature=share)

[feature=share](https://www.youtube.com/watch?v=iqDhLVLhVG4&feature=share) хаягаар үзэж болно.



Зургийг Александр Есипов

Узбекистаны тал нутгийн зэрлэг ан амьтад

Хятад дахь бөхөнгийн түүхий эд эрхтний уламжлалт ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Киан Хуанг, Айли Канг, Фенглиан Ли

Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газар.


Холбоо барих: qhuang@wcs.org

Шинжаан мужийн гаалийхан болон Торугарт хянан шалгах цэг дээр 2013 оны 9 сард Хятад руу хууль бусаар хил давуулахаар оролдсон 4470 бөхөнгийн эвэр бүхий 35 хайрцаг ачсан машиныг саатуулсан. Энэ нь сүүлийн жилүүдэд Хятад руу зэрлэг амьтны эд эрхтнийг хууль бусаар хил давуулахаар оролдсон томоохон хэргийн нэг юм. Энэ хэрэгтэй уялдуулан 2010-2013 оны хоорондох хэвлэлийн мэдээнд хийсэн анализаас үзвэл 12 бөхөнгийн эврээс эхлээд нийт дүнгээр 1901 орчим кг бөхөнгийн эврийг хураагджээ. Гурван хос эврийг ойролцоогоор нэг кг гэж үзвэл энэ нь 5708 эр бөхөнтэй тэнцэж байна.

Бөхөнгийн эвэр нь халуун бууруулахад ихээхэн үр дүнтэй ашиглагддаг учир Хятадын уламжлалт анагаах ухаанд өндрөөр үнэлэгддэг. Орчин үеийн эм зүйн судалгаагаар цочмог (ханиад томуу гэх мэт), ужиг явцтай өвчний(хавдар) эмчилгээнд чухал нөлөөтэй эмнэл зүйн нөлөөг үзүүлдэг болохыг харуулсан. Өнөөгийн байдлаар 60 гаруй түгээмэл ашиглагдаж буй эмийн жорны найрлагын гол бүрэлдэхүүн хэсэгт бөхөнгийн эвэр ордог байна. Хятадын бөхөнгийн эврийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа нь эдгээрийн томоохон импортлогч болгодог. Бөхөнгийн хууль бус агналтанд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь

бөхөнгийн эврийн худалдаа бөгөөд эр бөхөнг сонгон агнаснаас шууд үүдсэн популяцийн эр эм харьцаа алдагдаж, 1950-2000 он хүртэлх хугацаанд бөхөнгийн популяцийг 95% буурах нөхцлийг үүсгэсэн Иймээс хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судалж, шийдвэрлэх нь амин чухал асуудал юм. Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь төлөөлөгчийн газраас Хятадын уламжлалт анагаах ухааны зах зээлд 2 том төслийг хэрэгжүүлсэн. Үүний нэг нь 2006-2007 онд 14 мужийн бөөний болон жижиглэн худалдаа, хил орчмын зах зээлийг зорилтот бүлэг болгосон судалгаа юм (газрын зургаас хар) Бөөний худалдаа эрхлэгчдийн (242/262) 92% нь бөхөнгийн эврийн худалдааны талаар ярихдаа маш болгоомжтой хандаж байсан нь хууль бус худалдааны талаар өндөр мэдлэгтэй байгааг бид тогтоосон.

Хоёр жилийн судалгааны хугацаанд хууль ёсны олон улсын худалдаа байхгүй үед бөхөнгийн эврийн хууль бус наймаа хийж байсан, хууль бус агнуураар олзворлосон бөхөнгийн эврийг 121 дэлгүүрийн 6 хувь зарсан болохыг тогтоосон.



Хятадын ЗАХН-ээс судалгаанд хамрагдсан бүс нутгууд

оныхтой харьцуулахад 2013 онд 1,5 дахин нэмэгджээ. Хятадын засгийн газар үндэсний хэмжээний бодлого боловсруулан шинэчилсэнээр бөхөнгийн эврийн хууль бус худалдааг таслан зогсоох урьдчилсан арга хэмжээг аваад байна. Хуулийн зүйл заалтыг чангатгах ажлын хүрээнд ховордсон амьтны эд эрхтний худалдааг зохицуулах “Бөхөн, панголин, ховор зүйл могойн эмчилгээний бүтээгдэхүүний менежмент, хамгааллыг хүчирхэгжүүлэх талаарх мэдэгдэл” 2007 онд Хятадад хэвлэгдэн гарсан. Гэсэн ч бидний мониторинг судалгааны үр дүн цаашдын үйл ажиллагаанд хэрэгтэйг харуулж байна. Зах зээлийн мониторинг нь бөхөнгийн эврийн худалдаа, хэрэглээг багасгах, бодит байдалд нийцсэн бодлогын өөрчлөлтийг нөхцөлдүүлэх, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулахад чухал бүрэлдэхүүн хэсэг болох юм. Нэмж хэлэхэд, зориудаар бөхөнгийн нөхөн үржихүй доролцоо техник технологийн бэрхшээлийг шийдвэрлэн, бөхөнг зориудаар өсгөн үржүүлэх шинжлэх ухааны судалгааг төлөвлөх хэрэгтэй.

Зургийн Хятадын ЗАХН



ЗАХН-ийн ажилтан, сайн дурынхан зах зээлийн судалгааг гүйцэтгэж байгаа нь.

Энэхүү үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааг үргэлжлүүлэн, Хятад дахь дорно дахины уламжлалт эмчилгээний томоохон худалдааны зангилаа болох Гуанжоугийн Кинг Пинг уламжлалт эмчилгээний зах дээр ЗАХН 2009-2013 онд урт хугацааны мониторинг судалгааны хөтөлбөр хэрэгжүүлсэн.

Эмчилгээний, бэлэг дурсгал, эсвэл үнэ цэнэтэй ховор түүхий эд болгох гэсэн гурван үндсэн зорилготойгоор бөхөнгийн эврийг худалдаж авдаг байна. Урт хугацааны мониторинг судалгаанаас үзвэл бөхөнгийн эврийн зах зээлд зарим нэг хандлага бидэнд ажиглагдаж байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд, Хятадын шинэ жилийн баярын өмнө бөхөнгийн эврийн эрэлт ихэсдэг нь бие биедээ бэлэг өгөх уламжлалтай холбоотой. Бэлэгний зориулалтаар өгөх бүтэн эсвэл тал эврүүдийг худалдах нь Хятадын шинэ жил дөхөх үед дэлгүүрүүдэд түгээмэл ажиглагддаг. Бүтэн болоод тал эврийн үнэ 2009

Зургийн Хятадын ЗАХН



Уламжлалт эмийн бүтээгдэхүүний зах дээр зарагдаж байгаа эврийн ширхэг (зүүн), бүтэн эвэр (баруун)

Талархал

Бөхөнгийн популяцид тулгарч буй томоохон аюулын нэг рүү хандсан бидний судалгаанд хамтран оролцож, удирдан ажилласан Бөхөн хамгаалах нийгэмлэгт чин сэтгэлээсээ талархаж байна. Түүнчлэн зах зээлийн судалгааг гүйцэтгэхэд тусалсан сайн дурынханд талархаж байна. Энэхүү өгүүлийг тоймлосон Лондонгийн эзэн хааны коллежийн профессор Э.Ж.Милнар Гулланд, ЗАХН-ийн Вьетнам дахь хөтөлбөрийн ажилтан Жак Лам, ЗАХН-ийн Хятад дахь хөтөлбөрийн ажилтан Лишу Ли нарт гүнээ талархаж байна.

Астрахан мужид бөхөнгийн ороо хөөцөөний үед эр бөхөнг байгальд нь буцаан тавьлаа.

Н.А. Франов, В.В.Гагарин, М.В.Шиленко
"Астрахан" Төрийн мэдлийн Агнуурыг хөгжүүлэх ферм, nfranov@rambler.ru

Баруун хойд пре-Каспийн бүсэд (Халимагийн БНУ, Астрахан муж)тархан байршиж буй бөхөнгийн популяци нь харьцангуй цөөн тоотой үлдсэн. Тэдгээрийн популяцийн үнэлгээ нь одоогийн байдлаар 7000-аас бага тоотой байгаа бөгөөд алгуурханаар тасралтгүй буурсаар байна. Иймэрхүү ерөнхий бууралтын хажуугаар үржлийн эрэгчин амьтны тоо тогтвортойгоор буурч байгаа бөгөөд зарим нэг судалгаагаар нийт бодгалийн ердөө нэг хувийг эзэлж байгааг тогтоосон нь онцгой анхаарал татсан асуудал юм. Өнгөрсөн хугацаанд хэдэн хатуу өвлийн дараа ч гэсэн популяцийн 10-25%-ийг эзэлж байсан үржлийн эрэгчин амьтны тоо 3-5 % хүртэл хэзээ ч буурч байгаагүйг тэмдэглэх ёстой. Өнөөгийн байдлаар энэхүү нөхөн үржлийн хэмжээ тогтвортой түвшинд хүрээгүй байна. Энэхүү нөхцөл байдлын зайлшгүй үр дагавар нь сувай эмэгчний тоог нэмэгдүүлэн, популяцийн сөрөг хандлагыг нөхцөлдүүлж байна. ОХУ-ын ХАА-н яамны агнуурын хэлтэс 2001 онд Астраханы төрийн мэдлийн агнуурын хөгжлийн фирмийн бүрэлдэхүүнд бөхөн үржүүлгийн төв айгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2003 онд бөхөнгийн эхний сүргийг тэнд аваачсан (БМ №11-ээс хар). Өнөөдөр тэнд янз бүрийн нас хүйсний 31 бодгаль байна.

Баруун хойд пре-Каспийн популяцийг нөхөн сэргээх зорилгоор 2013 онд Астрахан мужийн Байгалийн нөөцийн менежмент, Хүрээлэн буй орчныг хамгаалах холбоо нь Астраханы үржүүлгийн төвөөс тус мужийн байгальд бөхөнг сэргээн нутагшуулах хоёр жилийн хөтөлбөрийг баталсан.

Ороо хөөцөөний үеэр байгальд эрэгчнийг буцаан тавих, урьчилсан арга хэмжээний тодорхойлолт (тусгаарлах, вакцинжуулах, том хашаанд чөлөөтэй байлгах гэх мэт); тавих аргачлал (суллан тавигдсан амьтанд сансрын дохиололтой хүзүүвч зүүх), эхний шатны үр дүнгийн үнэлгээ, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг нарийвчилсан үндэслэлийг уг хөтөлбөрт тусгасан. Бөхөн үржүүлгийн төвд хийсэн туршлагаас үзэхэд нэг эрэгчин 20-25 эм амьтныг хээлтүүлж чаддагт уг хөтөлбөр суурилсан. Энэ нь байгальд нэг үржлийн эрэгчнийг суллан тавьбал нэмж 30-40 бөхөн төрүүлэх үндэслэл болж чадахыг харуулж байна.

Эхний удаа 2014 оны 1 сард 2012 болон 2013 онд төрсөн 2 бөхөнг үржүүлгийн төвөөс Степной БНГ-т байх зэрлэг популяцид суллан тавьсан.

2012 онд төрсөн эрэгчин нь энэ жил ороо хөөцөөнд оролцож чадах бол 2013 онд төрсөн эр бөхөн өөрийн шинэ амьдрах орчинд дасан зохицож, үржилд орох насанд хүрч ирэх жил ороо хөөцөөнд оролцох ёстой гэж тооцоолсон.



2013 оны эр бөхөнг байгальд суллан тавихаас өмнө

Суллан тавигдсан бөхөнгүүдийг хянахын тулд бүс нутгийн хөрөнгө болон Астрахан фирмийн орлогоос худалдан авсан Аргос/GPS сансрын систем бүхий хоёр хүзүүвчийг зүүсэн. Хүзүүвчний батерейн ажиллах дундаж хугацаа 6 сар байсан.

Их биеийг нь битүү хучсан машинд бодгаль бүрийг тусад нь тороор тээвэрлэж байв. Тээвэрлэсний дараа эрэгчний биед үзлэг хийн шаардлага хангаж буй эсэх, ямар нэгэн бодит шарх байгаа эсэхийг үнэлэн, тухайн бодгалийн арьс үс сайн нөхцөлд байгаа эсэхийг тэмдэглэн авсан (Зур. 1).

Степной нөөц газрын ажилтнууд зэрлэг сүргийг хайн, суллан тавихад тохиромжтой нөхцөл байгаа эсэхийг шалгасан. Бөхөнгүүдийг 2014 оны 1 сарын 4-нд тааралдсан 50 гаруй толгой эмэгчний сүрэгт суллан тавьсан. Суллан тавихад Астраханы телевизийн кино багийнхан зураг авсан. (http://lotosgtrk.ru/news/detail.php?ELEMENT_ID=2710).


2013 оны эрэгчний шилжилт хөдөлгөөний эхний мэдээг 1 сарын 10-нд хүлээн авсан. Тэр эрэгчин өдөрт дунджаар 13 км зайг тогтмол туулж байсан бөгөөд нэг сүрэгтэй нийлсэн нь илэрхий байсан. Шилжилт хөдөлгөөн хийж буй газар нутаг нь Халимагийн БНУ-ын Ацан-Худук тосгон, Степной нөөц газрын Волга орчим, Астрахан мужийн Двадцатка малын үржлийн фирм хүртэлх газрыг хамран байршиж байв (зургаас хар).

Бөхөнг суллан тавьсан эхний хэдэн өдрийн туршид хийсэн ажиглалтын үед хөрш зэргэлдээ нутгаас амьтад бөөнөөрөө нүүдэллэн орж ирсэн тул бөхөнгийн тоо толгой (150 -200 хүртэл тоогоор сүрэглэсэн бөхөн харсан) нэмэгдсэн байсан. 2013 онд эдгээрээс 70 тоогоор сүрэглэсэн нэг сүрэгт байх эрэгчнийг дурангаад ажиглахад уг сүрэгт нэг ч эр амьтан ажиглагдаагүй. Нэгдүгээр сарын 17-нд суллан тавьсан эр амьтан Черные земли БНГ-ын хил дээр Степной БНГ-ын Волга мөрний эрэг хүртэл газар нутгийг хамран буйг сансрын дохиололын мэдээллээс тогтоосон. Энэ үед тухайн эрэгчин их эцэнхий байсан бөгөөд 1 сарын 19-22-нд

Черные земли БНГ-г урдөө нэг цэгээс л дохиолол хүлээн авсан бөгөөд 2 сарын 23-наас дохиолол дахин өгөөгүй байна. Степной болон Черные Земли БНГ-ын байгаль хамгаалагчид хамтран 3 сарын 4-нд эрэл, хайгуулын үйл ажиллагааг хийсэн. Волга бүс нутгаас зүүн тийш 12,5 км, Черные Земли БНГ-аас дотогш 6 км зайд хүзүүвчийг олсон. Хүзүүвчний ойролцоо энд тэндгүй тарсан үс, болон ясны үлдэгдэл байв. Уг эрэгчнийг чоно барьсан байсан.

Харамсалтай нь, 2012 онд төрсөн эрэгчний хүзүүвчний дамжуулагч нь суллан тавих газар луу бөхөнг тэвэрлэх явцад эвдэрч, хэвийн бус дохио дамжуулж байсан. Степной БНГ-ын ойролцоогоос (Двадцатка цирмийн хажуугаас) хүзүүвч бүрэн бүтэн олдсон газарт ямар нэгэн тэмцэлдсэн ул мөр, бөхөнгийн үлдэгдэл байгаагүйгээс үзэхэд бөхөнг хаа нэгтээ алаад, хүзүүвчийг энд үлдээсэн байх магадлалтай юм.

Ажиглалт болон хүзүүвчний мэдээллээс үзвэл 2013 оны эрэгчин зэрлэг бөхөнгийн популяцитай нэгдэн, сүрэгтэй цуг идэвхтэй шилжилт хөдөлгөөн хийж байсан бөгөөд мах идэшт амьтдад идүүлэхээс өмнөх 14-15 хоногт ороо хөөцөөнд идэвхтэй оролцож байжээ (чононд баригдсан бололтой)..



2013 оны эр бөхөнгийн шилжилт хөдөлгөөн

2012 оны эрэгчинг ороо хөөцөөнд оролцсон гэж бид таамаглаж байгаа боловч хүзүүвч эвдэрсэнээс шалтгаалан энэхүү таамаглалыг батлах боломж бидэнд байхгүй байна. Эрэгчин бөхөнг сэргээн нутагшуулах энэхүү хөтөлбөрийн хүрээнд зориудын нөхцөлд үржүүлсэн эрэгчин бөхөнг анх удаа байгальд нутагшуулах оролдлого амжилттай болж чадсан бөгөөд бөхөнгийн популяцийн тоо толгойг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа болохыг харуулсан. Бидний бодлоор ховордсон зүйлүүдийг хамгаалах улаан номонд бөхөнг хамруулах санал нь бөхөн хамгаалалд туслах явдлыг үгүй хийх төдийгүй бөхөн үржүүлгийн төвийн ажлыг нураах аюултай. Ингэснээр агнууртай холбоотой байгууллагууд бөхөн хамгааллын үйл ажиллагаанд оролцох, хамгаалалтай холбоотой шийдвэрүүдийг гаргахад оролцох боломжийг хязгаарлана (хэдийгээр зүйлийг хамгаалах талаар маш их зүйл хийсэн ч гэлээ). Энэ нь ЗХУ-ын болон ОХУ-ын аль алиных нь Улаанномонд ороогүй амьтад өөрсдийн анхдагч популяцийн хэмжээнд байгааг харуулах олон жишээ байна. Нэмж хэлэхэд, бөхөнгийн популяцид менежментэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл нь in situ болон ex situ хамгаалал бөгөөд ялангуяа энэхүү хоёр хандлагыг хослуулснаар ховордсон зүйлийг тогтвортойгоор нөхөн сэргээх гол хүчин зүйл болно гэдгийг бидний туршлага нотолж байна. Степной болон Черные земли БНГ-ын албан хаагчдад энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлсэн явдалд чин сэтгэлээсээ талархаж байна.



Уг хүзүүвчийн чоно тасдан хаяжээ.


Устюртын тал дахь эртний агнуурын байгууламж

Вадим Н. Ягодин, Ш.Ш. Амиров

Оросын ШУА-ийн Каракалпакын салбар; RI of human sciences
Under the Academy of Sciences of the RUz,
yagodin@gmail.ru

Устюртын тал нутаг дахь эртний агнуурын байгууламж 20-р зууны дунд үед археологийн ном зохиолд анх удаа дурдагдсан. 1952 онд Хантерсекийн эртний суурингийн ойролцоо Хорезмын археологийн угсаатны зүйн экспедицийн гишүүн С.П.Толстов агнуурын байгууламж байгааг тодорхойлсон бөгөөд тэрээр тал хээрийн сүрэглэдэг туруутан болох бөхөнг агнадаг “сааль” байж магадгүй хэмээн таамагласан [Редакци: Анчид амьтдыг занга руу хөөн оруулдаг].

Устюртын тал нутгийн урт хугацааны археологийн судалгааны хөтөлбөрийг 1970-аад оны эхэн үеэс Узбекистаны ЗСБНХУ-ын ШУА-ийн Каракалпак дахь салбарын Археологийн хэлтэс эхлүүлсэн. Энэ судалгаагаар эртний хөшөө дурсгалд судалгаа явуулж байсны дотор эртний агнуурын байгууламж болох арран буюу элээ гэж нэрлэгдэх зэв хэлбэрт байгууламжийг судалж байв [Редакци: Устюртын Каракалпакын хэсэгт олдсон арраны тухай товч мэдээ БМ№16-д хэвлэгдсэн]. Агаарын гэрэл зураг болон нэмэлт зураглал хийн боловсруулсаны үр дүнд Ягодин Бетте нар Хойд Устюртад цогц систем буюу эртний агнуурын томоохон байгууламжийг тодорхойлсон байна. Энэхүү систем нь Устюртын тал нутгийн зүүн хэсгээс эхлэн гинжин хэлбэрээр үргэлжилж, Дуана хошуунаас хойд зүгт 7 км-т дуусах бөгөөд зүүн хойш Косбулак болон Асмагай-Магайн давсархаг хөндий рүү сунасан байдалтай байна. Энэхүү систем нь тус тусдаа биеэ даасан 2 хэсэгт хуваагдах (Зураг 1) бөгөөд анчдын идэвхтэй



Зураг 2. Сансрын зурагт үндэслэн гаргасан Хойд Устюртын агнуурын байгууламжийн бүдүүвч зураг


оролцоогүйгээр бөхөн зэрэг сүрэглэн амьтадрдаг тал хээрийн туруутны бүхэл бүтэн сүргийг тэдний нүүдлийн замд нь агнах “идэвхгүй” агналтанд хамаарах байгууламж байна.

Сансрын судалгааны технологи, компьютер, газарзүйн мэдээллийн системийг, тухайлбал Google maps, Bing Map программ хангамж, TopoMapper.com болон Marshruty.ru цахим хуудаснаас SAS планетийн топограф зургийг ашиглан үзэхэд уг байгууламж нь бүхэл нутаг дэвсгэрт ажиглагдаж байна.

1970-аад онд уг агнуурын байгууламжийн 2 бүлгийг судалсаны үр дүнд 20 гаруй өмнө нь мэдэгдээгүй байгууламжийг илрүүлсэн (Зураг. 2).

Үндсэндээ Устюртын талд зүүн урдаас баруун хойш сунан тогтсон, зүүнээс баруун тийш уртаашаа 155 км, хойноос урагш 82 км нутаг буюу томоохон талбайг хамран уг байгууламж оршино (Зураг. 2). Эдгээр байгууламжийг 3 үндсэн хэлбэрт хуваан үзэж болно (Зураг. 3)

I хэлбэр. Сонгодог зэв хэлбэрийн байгууламж. Үүнд агнуурын байгууламжийн дийлэнх хэсэг нь хамаарах бөгөөд хойшоо харсан хаалга бүхий зэв хэлбэртэй, баруун болоод зүүн тийшээ хэлбийсэн байх бөгөөд урагшаа харсан мөн зэв хэлбэрийн хаалгатай байна. Ийм хэлбэрийн занга нь улирлын нүүдлийн зам дээр орших ба агнуурын явцад хүний үйл ажиллагааг бага шаардан зэрлэг туруутны зан төрхийг харгалзан баригдсан байна.



Зураг 1. Зайнаас тандан судлах мониторингоор Устюртын талд илэрсэн объектүүд.



Зураг 3. Зэв хэлбэртэй байгууламжууд. I хэлбэр – 1, 2; II хэлбэр – 4, 5, 6; III хэлбэр – 3.

Амьтад урагшаа чиглэн нүүдэллэх өвлийн нүүдлийн үед хойшоо чиглэсэн гарцууд идэвхтэй байх ба хойшоо чиглэн нүүдэллэх хаврын шилжилт хөдөлгөөний үед өмнө зүг харсан гарцууд нээлттэй байдаг байна. Эдгээрийн 68 нь эхний хэлбэрт хамаарах бол 18 нь хоёрдугаар хэлбэрт хамаарна.

II хэлбэр. 190 *170 метр хүрдэг эллипс буюу “гурван талт” хэлбэртэй дугуй хашаа. Одоогоо тэдгээрийн үйл ажиллагаа тодорхой бус. Нийт тоо 25.

III хэлбэр: Косбулак ба Матайн давсархаг хөндийн хооронд орших 430-550 метр урттай тэдгээрийн хоорондох амьтны шилжилт хөдөлгөөнийг үндсэндээ хаасан байгууламж. Эдгээр нь 1-р хэлбэрийн агнуурын байгууламжийг санагдуулам “шуудай” эсвэл зэв хэлбэрт байгууламжаас бүрдэнэ (Зураг 2). Эдгээр нь өвөл болон хаврын нүүдлийн үед ашиглагддаг байж болох юм. Энэ хэлбэрт хамаарах 7 байгууламж олдсон. Эдгээр агнуурын байгууламж нь томоохон газар нутгийг хамарсан хэдэн арван байгууламжаас бүрдэх бөгөөд эдгээрийг барихад асар их хөдөлмөр шаардагдсан байх ёстой. Давтан барьсан ул мөр олонх агнуурын байгууламж дээр харагдаж байна.

Хойд Устюртын энэхүү агнуурын байгууламж нь урт хугацаанд оршин байгаа нь тодорхой бөгөөд эдгээрийг барьж байгуулахад олон хүмүүс удаан хугацаанд оролцсон нь ойлгомжтой юм.

Устюртын энэ хэсэгт байх олон тооны хиргисүүр байдаг бөгөөд энд үхэр маллахын зэрэгцээгээр Хойд Устюртыг бүхэлд хамарсан агнуурын байгууламжийг барьж, бий болгож байсан бөгөөд ангийн бүтээгдэхүүнийг боловсруулдаг байжээ. Анхны агнуурын байгууламж М.Э.Ө 1000 жилийн тэртээ үүссэн бөгөөд хүмүүс М.Э 7-8-р зуун хүртэл тэдгээрийн сайжруулан, дахин барьж үргэлжлүүлэн ашиглаж байв.



Цаасан илгэрүүлсэн авсан зураг

Зураг 4. Буланбайн байгууламж, зүүн хойд хэсгийн харагдах байдал.



Орон зайн зураг (Bing Maps™)

Зураг 5. Дуаны оршуулгын газрын ойлцоох дахин байгуулсан зэв хэлбэрт байгууламж

Арал-Каспийн тэнгисийн усан хагалбарын эртний агнуурын байгууламжын ерөнхий систем доторх Хойд Устюртын энэхүү байгууламжуудыг авч үзвэл энэ бүс нутагт байрших өвөрмөц зүйл болохыг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь “идэвхгүй” агнуурт зориулагдсан бөгөөд Дуаны оршуулгын газрын байгууламжинд олон хүмүүсийн булш, агнуурын ёслолд ашиглагдах байгууламж мөн байна.

Бөхөнгийн баатар



Зургааг Ж.Ф.Ласрот

Редактор: Та хэзээнээс бөхөнг сонирхож эхлэсэн бэ?

Ю.А.: Би 1963 онд АН-2 онгоцоор агаарын судалгаа гүйцэтгэж явахдаа анх удаа бөхөнг өндрөөс харсан. Тухайн үед бөхөнгийн популяци маш том байсан учир ч хэдэн зуу, хэдэн мянгаараа сүрэглэн гүйж яваа амьтдыг харж чадах байсан. Үүнийг хараад маш их сэтгэл хөдөлсөн. Хэдийгээр миний үндсэн эрдэм шинжилгээний ажил уулын туруутан болон том мах идэшт амьтад руу чиглэгдэж байсан хэдий ч үүнээс хойш олон удаа бөхөнгийн агаарын тооллогонд оролцсон. Гэвч зөвхөн агаарын судалгаа төдийгүй бөхөнгийн экологийн судлах хээрийн хайгуул судалгаанд оролцоходоо маш их баяртай байдаг. Энэхүү гайхалтай амьтан миний сонирхлыг татаж эхлэсэн.

Редактор: Та хэзээнээс бөхөнгийн судалгааны ажлаа болоод тэдгээрийн хамгаалал руу чиглэсэн үйл ажиллагаагаа эхэлсэн бэ?

Ю.А.: Бөхөнгийн судалгаа манай хөхтний лабораторийн хувьд эн тэргүүнд хийгдэх ажил байсан. Амьтан судлаач Аркадий Слудскийн (1978 он хүртэл) удирдсан лаборатори Казахстаны бөхөнгийн ангилалзүйн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэсэн. Виталий А.Фадеев бөхөнгийн экологийн судалгааг 1966-1980 онд гүйцэтгэж байв. Тэдгээрийн судалгааны үр дүнг тусгасан “Казахстаны бөхөн”(Фадеев&Слудский 1982) ном хэвлэгдсэн. В.Фадеев 1987 онд зуурдаар нас нөгчсөний дараа миний бие лабораторийн бөхөнгийн судалгааг хариуцан өнөөг хүртэл хийж байна.

Устюрт болоод Мангышлакын хаа нэгтээ олдсон агнуурын байгууламж нь 9-14-р зууны сүүл үед хамаарах бөгөөд дийлэнх нь “идэвхтэй” агнуурын хэлбэрт хамаарагдана. Тэдгээр нь том хэмжээний газар нутгийг хамарсан идэвхгүй хэлбэртэй бус, өөрөөр хэлбэл нэгдмэл бус салангид бүтэцтэй байгаа нь спорт агнуурт илүүтэй чиглэгдсэн байж болохыг харуулна.

Энэ удаа бид Казахстаны Боловсрол, Шинжлэх ухааны яамны Амьтан судлалын хүрээлэнгийн ахлах ажилтан, Биологийн ухааны доктор Юрий Грачевтай ярилцаж байна. Доктор Грачев хөхтөн амьтны экологи, хамгаалал, ашиглалт, ялангуяа туруутан болон мах идэшт амьтдыг сонирхон судалдаг байна. Тэрээр энэ судалгаан дээр 1962 оноос хойш ажиллаж байгаа бөгөөд бөхөнгийн тухай олон өгүүлэл бичсэн бөгөөд 1998 онд Москва хотноо түүний “Бөхөн (гарал үүсэл, ангилалзүй, экологи, хамгаалал, ашиглалт)” нэг сэдэвт бүтээл хэвлэгдэн гарчээ. Юрий Грачев бол бөхөнгийн экологи, зан төрхийн талаар дэлхийн хэмжээний эксперт бөгөөд бөхөн судалдаг хэн боловч гүнээ хүндэлдэг хүн юм.

Редактор: Таны хувьд нэг өдөр хэрхэн өнгөрдөг вэ?

Ю.А.: Хээрийн нөхцөлд ажиллах үедээ (дуран болон телескоп ашиглан) тохиолдсон бөхөнг ажиглах болон судалгааны замналыг гүйцэтгэхэд ихэнх цагаа зарцуулдаг. Төллөх үед янзагыг ээмэглэх, жинг хэмжих, хүйсийг тодорхойлох гэх мэт ажлуудыг гүйцэтгэнэ. Хотод ажиллах зуураа цуглуулсан материалаа боловсруулах, тайлан, өгүүлэл бичих, уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцох гэх мэт ажлыг хийдэг дээ.

Редактор: Та бидэнд бөхөнгийн тухай сонирхолтой түүх ярьж өгнө үү?

Ю.А.: Бөхөн нь маш олон сонирхолтой зуршилтай бөгөөд тэдгээрийг тайлбарлах аргагүй. Жишээлбэл, бөхөнгийн усан саадыг давах арга зам...Нэгэн хавар манай отог Тургай голын эрэг дээр байрлаж байв (5-р сар). Тэнд маш олон бөхөн байсан бөгөөд тэд тодорхой бус шалтгаанаар урагш, хойш голыг хөндлөн гарч байв. Энэ нь тэндийг “сэлж буй” мэт харагдуулж байсан. Нэмж хэлэхэд бөхөнгийн нэг сүргийн нүүдлийн замд 11 сард нуур хөлдөхөөс өмнө өргөн нуурыг дайран гарах шаардлага гарсан. Хэдийгээр нуураас холгүй түүнийг тойрон гарсан зам байсан ч бөхөнгүүд үүнийг зогсолтгүйгээр хөндлөн гарсан.

Редактор: Таны ажилд тулгарч буй гол асуудал юу вэ?

Ю.А.: Юуны түрүүнд судалгааны санхүүжилт дутагдалтай байдаг явдал. Иймээс энд залуу судлаачдыг оролцоог хангах түлхэц юу ч алга.

Редактор.: Таны ажлын хамгийн сайн тал нь юу вэ?

Ю.А.:Би амьтан харах зорилготойгоор хээр аялах болон судалгаа болон бөхөнгийн хамгаалалд янз бүрийн улсаас хүрэлцэн ирж оролцож буй найзууд, хамтран ажиллагч нартайгаа хамт байх дуртай.

Редактор.: Бөхөн хамгааллын хэтийн төлөв юу вэ? Энэ зүйлийн эсэн мэнд үлдэлтэнд туслахын тулд эхний ээлжинд юу хийх ёстой вэ?

Ю.А.:Казахстаны бөхөнгийн тоо толгой 1990 оны бууралтын дараа дахин өсөж эхэлсэн. Энэ нь бидэнд ирээдүйд итгэх итгэлийг өгсөн. Гэсэн хэдий ч энэ бүс нутагт хууль бус ан агнуур үргэлжлэн явагдаж, өвчний улмаас бөөнөөрөө хиарах үзэгдэл байсаар байна. Золоор бөхөнгийн өвчний талаарх зарим нэг судалгаа хийгдэж эхэлж байна. Хууль бус ангийн нөхцөл байдал илүү их асуудал дагуулж байна. Хууль хэрэгжүүлэх бүх байгууллагуудын хамтын үйл ажиллагаа, орон нутгийн иргэдтэй урт хугацаанд хамтран ажиллах нь ихээхэн чухал байна. Өнөөг хүртэл бөхөнгийн тоо толгойг цөөрүүлж буй үндсэн шалтгааны нэг болох нь ажиглагдсаар байна.

Редактор.: Та сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд ховор зүйлүүдийн хамгаалал, судалгааг гүйцэтгэж байна. Энэ хугацаанд юу өөрчлөгдсөн бэ? Энэ бүс нутгийн өнөөгийн хандлага ямар байна вэ?

Ю.А.:Ерөнхийлэн хэлэхэд Казахстаны ховор зүйлүүдийн хамгаалах ТХГН-уудыг өргөтгөж, зарим нэг газруудыг шинээр хамгаалалтанд авсанаар сайжирч байна. Эдгээр БЦГ болон БНГ юм. Нэмж хэлэхэд



Зурвалж: Ж.Ф. Лазаров

Юрий Грачев, Алайн Кухл нар шинэ төрсөн янзагыг хэмжиж байна.

ховор туруутны зүйлийг (аргаль, зээр, онагер, Бухар буга, бөхөн) хамгаалах, судлахад чиглэсэн цөөн хэдэн төсөл 2005 оноос хойш хэрэгжиж байна.

Мэдээлэл

Бөхөн хамгаалах нийгэмлэг, Залуу хамгаалагч лидер-2014

2014 оны 6 сард БХН-ийн Залуу хамгааллын лидер шагналын ялагчдыг зарласан. Энэ нь энэ жил анх удаагаа олгогдож байгаа шагнал бөгөөд үүнийг жил бүр өгдөг болно гэдэгт итгэлтэй байна. Энэхүү шагнал нь бөхөн хамгаалагчдын хойч үеийг дэмжих, бөхөнгийн тархац нутагт оршин сууж буй хамгааллын лидерүүдийн ажлыг санхүүжүүлэх, бөхөн хамгаалалд тэдний оруулж буй хувь нэмрийг таньж мэдэх, бөхөнгийн дэлхэц нутгийн хүрээнд тэднийг оролцуулсан сүлжээг үүсгэх зорилготой. Энэхүү 2014 оны шагналыг Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс санхүүжүүлсэн бөгөөд бид ЗАХС-гээр дамжуулан энэхүү ажлыг дэмжсэн бүх ивээн тэтгэгч нарт талархаж байна.

Энэхүү шагналыг авахыг хүсэгчид бөхөнгийн тархац нутагт оршин суух 18-30 хүртэлх насны бүх хүнд нээлттэй байсан. Залуу хамгаалагч лидер бүр нь өөрсдийн ажлын цар хүрээг нэмэгдүүлэхийн тулд 12 сарын турш 1000\$ авахаас гадна БХН-ийн дэмжлэг, заавар зөвлөмжийг авах боломжтой болно. Энэ оны 5 сард Узбекистанаас Олга Есипова, ОХУ-аас Айгүл Айтбаева, Монголоос Эрдэнэбаатарын Сэргэлэн гэсэн 3 ЗХЛ сонгогдсон. Залуу хамгаалагч лидер бүрээс ирэх жил хүртэлх хугацаанд энэхүү хөтөлбөр нь хэрхэн

тэдний ажилд тусалж буй талаарх товч дүгнэлт бичин өөрсдийгөө танилцуулж байна.

Айгүл Айтбаева, ОХУ.

Баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцийн тархац нутагт хамаарах Халимагийн Ящкул дүүрэгт амьдардаг надад бөхөнгийн өнөөгийн нөхцөл байдал ихээхэн танил байдаг. 2011 онд Астраханы Улсын их сургуулийг төгсөөд, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвд ажиллаж эхэлсэн. Миний бие уг төвд 3 жил ажиллаж байгаа бөгөөд өдөр өнгөрөх тусам илүү их дадлага туршлага сууж, энэ ажилд илүү их оролцдог болсон. Миний хариуцдаг ажил их олон талтай боловч хүрээлэн буй орчны талаарх боловсролын асуудалд анхааран, бөхөн хамгааллын тухай хүүхдэд зориулсан лекц уншиж, жил бүрийн “Бөхөн хамгаалах өдөр” гэх мэт ажлуудыг зохион байгуулж, Ящкулын бөхөн үржүүлгийн төв рүү хүүхдэд зориулсан аялал зохион байгуулдаг. Би “Амьд өв” нэртэй хүүхдийн хүрээлэн буй орчныг хамгаалах клубийг Ящкул тосгонд үүсгэн



байгуулсан. Ирээдүйд иймэрхүү клубыг бусад тосгонд үүсгэн байгуулж, хүрээлэн буй орчныг хамгаалах үйл ажиллагаанд залуу үеийн оролцоог улам бүр нэмэгдүүлэхийг хүсдэг.

Залуу хамгаалагч лидер шагнал нь 5-7-р ангийн сургуулийн хүүхдэд зориулсан “Гайхалтай нүүдэлчин” өнгөт товхимолыг бүтээхэд туслах болно. Энэхүү товхимол нь бөхөнгийн талаарх хүүхдүүдийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэхээс гадна тэдний сонирхлыг төрүүлж, бөхөн хамгаалах урам зоригийг өгөх болно. “Гайхалтай нүүдэлчин” товхимол нь БХН-ээс хэрэгжүүлж буй “Буддист залбирагчид ба бөхөнгийн тархац нутагт амьдарч буй хүмүүст өгөх лекцийг зохион байгуулах” төслийн хээрийн аялалын үед тараагдах болно. Халимагийн сургуулиудад уг товхимолыг хэвлүүлэн тараах зорилгоор нэмэлт санхүүжилт хайх болно.

Олга Есипова, Узбекистан.



Миний бөхөн хамгааллын ажил анх зэрлэг ан амьтны хамгааллыг сонирхож эхэлсэн цагаас буюу жилийн өмнөөс үүдэлтэй. Би Бөхөнгийн нөөцийн төвд Англиас орос руу орчуулга хийж эхэлсэн ба Устюртын тал руу хээрийн аялалд оролцдог байв. Энэ ажил нь бөхөн хамгаалалд би өөрийн хувь нэмрийг оруулах хэрэгтэй гэдгийг ухаарч ойлгоход тусалсан бөгөөд үүнээс эхлээд би зэрлэг ан амьтдын тухай улам илүүг мэдэхэд шунан дурлаж, Бөхөн хамгаалах нийгэмлэгт сайн дурын ажилтан хийж байгаа баяртай байсан. Бөхөнгийн тухай дууны видеог бүтээх, бичүүлэхэд, мөн үүнийг англи

руу хөврүүлэхэд тусалдаг. Түүнчлэн орчуулагчийн үүрэг гүйцэтгэн, автомат камер тавих тухай сургалтанд оролцсон. Миний хамгийн сүүлд оролцсон, магадгүй хамгийн чухал байж болох зүйл нь тал хээрийн түлхүүр зүйл болох бөхөнг дунд сургуулийн хананд зурахад тусалсан явдал юм. Би уг бүтээлд өөрийн хувь нэмрийг оруулсандаа, орчуулагчаар оролцон тусалсандаа маш их байртай байсан.

Би залуу хүмүүстэй хамтран ажиллахыг хүсдэг бөгөөд ЗХЛ-ийн шагнал нь тал хээрийн зэрлэг амьтад хамгаалах клуб болон орон нутгийн сургуультай хамтран ажиллах, энэ намар болох Нүүдэллэдэг зүйлүүдийн өдрөөр бөхөнгийн талаар мэдээлэл сурталчилгаа явуулахад өөрийн цаг хугацааг зориулахад надад туслах болно. Мөн хүүхдэд зориулсан зарим нэг үйл ажиллагааг явуулах, зэрлэг амьтан хамгааллын талаар хэлэлцүүлэг, хичээл зохион байгуулахаар төлөвлөж байна. Түүнчлэн тосгодын залуусын дунд хамгийн сайн экологийн төслийн уралдааныг зохион байгуулах хүсэлтэй байна. Үүний үр дүнд хүүхэд багачуудыг байгаль дэлхийгээ хайрлан хамгаалдаг болоход төдийгүй залуу хамгаалагчдын дараагийн үед урам зориг өгөхөд туслах болно гэдэг итгэлтэй байна.

Эрдэнэбаатарын Сэргэлэн, Монгол.



Би Ховд аймагт амьдардаг бөгөөд Алтайн нүүдэлчид ТББ болон Дэлхийн байгаль хамгаалах санд ажилладаг. Бөхөн хамгаалах ажилд 2013 оны 6 сараас хойш оролцон ажиллаж байна. Надад хамгийн их сэтгэгдэл үлдээсэн ажлын нэг нь “Бөхөнгийн тархац нутагт орших хоёр ТХГН-ийн (Шарга, Манханы БНГ) менежмент төлөвлөгөө боловсруулах” ажил байсан. Энэ төслийн хүрээнд орон нутгийн малчид, малчдын бүлэг нөхөрлөлийн оролцоотойгоор менежмент төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Манхан БНГ-ын менежмент төлөвлөгөө нь батлагдсан бөгөөд Шаргын БНГ-ын менежмент төлөвлөгөөний хэлэлцүүлэг хийгдэж байгаа.

2013 оны 11 сард бөхөн тооллогын ажилд оролцон, бөхөнгийн үндсэн идээшил нутагт тооллогын ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Мөн бөхөнг тархац нутагт нь сэргээн нутагшуулах болмжийг тодорхойлох судалгаанд оролцсон. Эдгээр судалгаа нь ирээдүйд бөхөн хамгааллын үйл ажиллагааг төлөвлөхөд ашиглагдах бөгөөд бөхөнгийн тархац нутгийн зургийг сайжруулахад ашиглагдаж байна.

ЗХЛ шагнал нь цаашид бөхөнгийн судалгааг гүйцэтгэхэд туслах болно. Би орон нутгийн байгаль хамгаалагчид, хоёр их сургуулийн оюутнуудтай хамтран 6 сарын 13-25-ны хооронд бөхөн төллөдөг нутгуудыг тодорхойлох судалгааг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Бөхөнгийн төллөлт явагддаг нутгуудыг нарийвчлалтай тогтоон гаргах нь мах идэшт шувуудын аюул заналыг бууруулах, шинэ төрсөн янзаганд нөлөөлж буй байгалийн хүчин зүйлүүдийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой. Бид бөхөнгийн чухал тархац нутгийн нэг болох Дөргөний хүрэн талд энэ судалгааг гүйцэтгэх бөгөөд уг нутагт хамгааллын ямар нэгэн үйл

ажиллагаа явагдаагүй байна. Энэ бүс нутгийн ойролцоо хууль бус агнуур ихээхэн явагдаж байгаа бөгөөд хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх нь ихээхэн чухал ач холбогдолтой байх болно. Тухайн судалгааг трансектын арга зүйн дагуу гүйцэтгэх бөгөөд цаашдын бөхөн хамгааллын үйл ажиллагааг төлөвлөхөд ашиглагдах болно.

БХН тус нийгэмлэгийн ивээн тэтгэгч Жой Ковейгийн дурсгалд зориулан бөхөн хамгаалах шагналыг олголоо



Зүүн гар талаас: Степной БНГ-ын байгаль хамгаалагчдын баг, Иргыз Тургай БНГ-ын хууль бус антай тэмцэх баг, Балжиннямын Батсайхан.

Энэхүү шагналыг сүүлийн 12 сарын туршид бөхөнгийн хууль бус агнууртай тэмцэхэд амжилт гаргаж, бие сэтгэлээ харамгүй зориулсан төрийн болоод төрийн бус байгууллагын хатм олон, хувь хүмүүст олгохоор болсон. Нэр дэвшигчдийн хүрсэн ажлын амжилт нь маш сайн байсан бөгөөд ялагчдыг сонгон авахдаа дор дурдсан 3 номинацаар шалгаруулан багт \$1,000, харин 2 өрсөлдөгчид тус бүр \$750 шагнал өгөхөөр шийдвэрлэсэн.

- 1-р байр: Казахстаны Иргыз Тургай БНГ-ын хууль бус антай тэмцэх баг. Энэхүү хууль бус антай тэмцэх багийн цуцалтгүй хамгааллын ажлын үр дүнд Бетпақдалагийн

бөхөнгийн популяци сүүлийн 7 жилд тогтвортой өсөх нөхцөл бүрдсэн.

-2-р байр: ОХУ-ын Степной БНГ-ын байгаль хамгаалагчдын баг. Баруун хойд пре-Каспийн нутагт маш хүнд хэцүү нөхцөлд бөхөн хамгаалахаар ажиллаж буйг үнэлсэн.

-2-р байр: Балжиннямын Батсайхан, Монголын байгаль орчны улсын байцаагч. Монголын бөхөн хамгаалагчдын сүлжээг үүсгэн байгуулсан түүний хүчирхэг хамтын ажиллагааг хангасан удирдлага нь хууль сахиулах, хамгаалах бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн загвар болсон.

Бүх ялагчдад баяр хүргэе!

Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэг Дэвид Маллоний бөхөн хамгаалах талаар хийсэн ажлыг үнэлж байна.

ЛАСН-ийн Стэмфорд Рэффлийн шагналыг мэргэжлийн болон сонирхогчийн хүрээнд амьтан судлалын салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн олгодог. Энэ жил уг шагналыг БХН-ийн итгэлтэй, дотны нөхөр Дэвид Маллонд олголоо. Уг шагналыг гардуулахад ЛАСН-ээс хэлсэн үгийг иш татав:

“түүний ажил нь Английн их сургуулийн багш, экологийн зөвлөх бөгөөд Дэвид бол олон улсын байгаль хамгаалалд нэр дурдагдаагүй баатар юм. Тэр ДБХХ-ны туруутны мэргэжлийн багийн дэд дарга бөгөөд ДБХХ, Амьтан ургамал хамгаалах олон улсын байгууллага, бусад байгууллагуудын өргөн хүрээтэй хамгааллын үйл ажиллагааг бий болгосон.

Дэвидын хамгааллын ажил нь Төв болон Зүүн Ази, Энэтхэг, Ойрхи дорнодын бүс нутагт гол анхаарлаа тавин хийгдэж байна. Тэрээр 1989 оноос эхлэн туруутан амьтны Улаан дансны үнэлгээний хэсэгт ажилладаг бөгөөд Хойд Африк, Ойрхи дорнод, Ази тивийг хамруулан ДБХХ-ийн туруутны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Дэвидийн хэрийн судалгааг гүйцэтгэх асар их туршлага, мэдлэг, хэлний гайхалтай авъяас нь хамгааллын ажлыг үнэхээр ач холбогдолтой, амжилтанд хүргэсэн байна.



Зурвалж: ЛАСН

Дэвид Маллон ЛАСН-аас авсан медаль, сертификатын хамт

Ялангуяа, Дэвид хамгааллын болон тэдгээрийн хөгжүүлэх аливаа асуудалд тухайлбал: мэдээлэл дутмаг байгаа туруутны мэдээллийг сайжруулахад, ховордож буй туруутны хамгаалалд хээрийн үйл ажиллагааг төлөвлөн явуулах, тухайн бүс нутгийн чадавхийг сайжруулах, устаж үгүй болсон туруутан амьтныг сэргээн нутагшуулах ажлыг дэмжих,

ДБХХ-ны Улаан дансны ховордсон зүйлүүдийн бүс нутгийн үнэлгээг хийхэд олон улсын байгууллага, нөхөрлөлийг оролцоог хангахад анхаардаг туруутны багийн мэргэжилтэн юм. Түүний энэ бүх ажлууд бүгд сайн дурын үндсэн дээр хийгдэж байна.”

Энэхүү нэр хүндтэй шагналыг хүртсэн Дэвидэд чин сэтгэлийн баяр хүргэе!



Зургийг Евгений Полоцкий

ОХУ, Астрахан муж, Степной БНГ-т ус ууж буй бөхөнгийн сүрэг.

Талархал

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагаанд өөрсдийн үнэт цаг зав, мөнгөөр дэмжлэг үзүүлсэн бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархлаа илэрхийлж байна. Ялангуяа Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний албан хаагч, сайн дурынханы дэмжлэг, заавар зөвлөгөөнд онцгойлон талархаж байна. Цувралын энэхүү дугаарыг ивээн тэтгэсэн Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, ЗАХН-ийн Хятад дахь хөтөлбөрийн газарт гүнээ талархаж байна.

Редакторын баг.Хятад: А. Канг (akang@wcs.org)&Фенглиан Ли (fli@wcs.org)ЗАХН, Хятад дахь хөтөлбөрийн газар, ; Казахстан: Профессор А. Бекенов&докЮ.А. Грачев, Амьтан судлалын хүрээлэн (teriology@mail.ru), Г.Изимбергенова, КБТЗХН (gulmira.izimbergenova@acbk.kz); Монгол: докторБ.Лхагвасүрэн (lkhagvazeer@gmail.com)&Б. Чимэддорж (chimeddorj@wwf.mn), ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Орос: Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв (saiga-center@mail.ru) &док А. Луцкекина, Экологи эволюцийн хүрээлэн (saigak@hotmail.com); Узбекстан: Е. Быкова [Гүйцэтгэх редактор] &док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн (esipov@xnet.uz); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk) &докДавид Маллон [Шүүмжлэгч], ДБХХ, Туруутны мэргэжлийн баг,d.mallon@zoo.co.uk; График дизайныг Виктор Григориев, mooglik@mail.ru.

Бүх өгүүлийг бидний хэрэглэдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүлийг esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Материалаа esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.